

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	0
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-2
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	3-32

---

- 1. Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/** 3-32

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 33 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: П.Батчимэг, Л.Мөнхбаясгалан;  
Чөлөөтэй: С.Ганбаатар, Ц.Мөнхбат, З.Мэндсайхан, Б.Найдалаа, Р.Сэддорж;  
Эмнэлгийн чөлөөтэй: М.Мандхай, С.Лүндэг.

**Нэг.Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл /Засгийн газар 2025.01.08-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, мөн яамны Салбарын хяналтын газрын дарга Б.Мөнхтогтох, Усны газрын дарга З.Батбаяр, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга С.Төгсжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга Г.Манлайжав, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Б.Хулан, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн газрын дарга Л.Наранчимэг, Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, “Мон-Атом” ХХК-ийн захирал Д.Далайжаргал, мөн компанийн Уул уурхайн ахлах инженер А.Алтанхундага, Олон улсын харилцааны судлаач Д.Баярхүү, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр, “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн Геологи, уул уурхайн хэлтсийн ерөнхий менежер Л.Өнөрбаатар, мөн компанийн Санхүү, шинжилгээний хэлтсийн ерөнхий менежер Б.Баяр-Өлзий, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ц.Мөнх-Оюунбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Чинбүрэн, Б.Уянга, Ж.Батжаргал, А.Ундраа, Г.Ганбаатар, Ц.Идэрбат, Н.Наранбаатар, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга Г.Манлайжав, мөн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, “Мон-Атом” ХХК-ийн захирал Д.Далайжаргал, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, Олон улсын харилцааны судлаач Д.Баярхүү, Физикийн ухааны доктор Н.Тэгшбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, С.Замира нар үг хэлэв.

**Б.Бейсен:** Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13  
Татгалзсан: 2  
Бүгд: 15  
86.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 50 минут үргэлжилж, 24 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 23 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим, 14 цаг 33 минут

### **БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Бейсен:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 62,5 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны нээснийг мэдэгдье.

Ирцийг танилцуулъя. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Очирбатын Амгаланбаатар ирсэн. Телеуханы Аубакир гишүүн ирсэн. Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн. Жамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн. Гомбын Ганбаатар гишүүн ирсэн. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн. Сонгобай н Замира гишүүн ирсэн. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн. Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн. Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн. Болдын Уянга гишүүн ирсэн. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын Засгийн газрын болон Монгол Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөл Засгийн газар 2025 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэх ёстой.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу. Байхгүй байна. Хэлэлцүүлгээ эхэлье.

**Монгол Улсын Засгийн газрын болон Монгол Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хооронд хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл.**

Төслийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ням-Осорын Учрал танилцуулна.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Орано Майнинг С.А.С компанийн хооронд байгуулах уран олборлох төслийн хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Монгол Улсын эрх ашиг, хууль тогтоомжид нийцүүлэн хөрөнгө оруулагч талтай урьдчилан тохирч боловсруулж, Цөмийн энергийн тухай хуулийн 30.3-д заасны дагуу зөвшилцөхөөр Улсын Их Хуралд танилцуулж байна.

Зөөвч-Овоо Дулаан-Уулын ураны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах энэхүү төсөл нь хамтарсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн улсын хөгжлийн бүтээн

байгуулалтын 14 мега төслийн 1 бөгөөд энэхүү гэрээг хэрэгжүүлснээр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, улс орон нутгийн төсөвт хөрөнгө төвлөрүүлэх, ажлын байрыг бий болгох, шинэ технологи нутагшуулах, мөн олон улсын хамтын ажиллагаа зэрэг нийгэм, эдийн засагт үзүүлэх шууд нөлөөллөөс гадна, цаашид уул уурхай ашигт малтмалын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын гэрээнд жишиг тогтоох үр дагавартай.

Хөрөнгө оруулагч нь Монгол Улсад 1997 оноос хойш хайгуул олборлолтын чиглэлээр тасралтгүй 27 жил үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 2021 оны 7 дугаар сараас Зөөвч-Овоо ордын үйлдвэрлэлийн туршилтын ажлыг эхлүүлж, 2022 оны 12 дугаар сард амжилттай хэрэгжүүлж дууссан. 2023 оны 5 дугаар сараас эхлэн Монгол Улсын Ерөнхий сайдын хэд хэдэн захирамжаар Хөрөнгө оруулалтын гэрээний төслийн хэлэлцээг хийж, эцэслэн боловсруулсан хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгүүд тус ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, хөндлөнгийн төлөөлөл бүхий өргөн бүрэлдэхүүнтэй ажлын дэд хэсгүүдийг гэрээ, эрх зүй, эдийн засаг, хөрөнгө оруулалт, татвар, санхүү, олборлолт, үйлдвэрлэл технологи, байгаль орчин, орон нутаг гэсэн 5 чиглэлд байгуулж, хэлэлцээг үргэлжлүүлэн эцэслэн хувилбарыг боловсруулан ажиллалаа.

Ажлын хэсгээс гэрээний төслийн хувилбарыг боловсруулахдаа Монгол Улсын эрх ашигт нийцсэн стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа дийлэнх үр өгөөж ард түмэнд ноогдож байх талуудын хүртэх өгөөжийг тэнцвэртэй хангах суурь зарчмуудыг хатуу баримталж ирээдүйд аливаа эрх зүйн үр дагаваргүй хэрэгжих боломжийг бүрдүүлэх, цаашид жишиг гэрээ болох нөхцөлийг хангахад анхаарч ажиллалаа.

Мөн энэ чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий мэргэшсэн санхүү, хууль, байгаль орчны зөвлөхүүд болон дотоодын зөвлөхүүд хамтран ажилласныг онцлох нь зүйтэй. Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүйн зарчмыг баримтлан хөрөнгө оруулагчдаа нийт 18 удаагийн хэлэлцээг хийж Монгол Улсын эрх ашгийг Монгол Улсын Үндсэн хуулийн суурь зарчимд нийцүүлэн боловсрууллаа.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар ахлуулсан ажлын дэд хэсэг ажиллаж, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дараах нөхцөлүүдийг урьдчилан тохиролцсон болно.

Үүнд: Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдийн илэрхийлсэн байр суурь, гаргасан саналыг үндэслэж, Байгаль орчны салбарын албан татварыг тогтворжуулахгүй, Монгол Улсын хууль тогтоомж олон улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулах нөхцөлүүдийг тусгалаа.

Олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлж, байгаль орчны хяналт, мониторингийг гүйцэтгэхэд олон нийтийн оролцоог хангаж, 3 жил тутамд төслийн үйл ажиллагаа болон технологид олон улсын атомын энергийн агентлагийн шинжээчдээр хөндлөнгийн аудит хийлгэх үүргийг төсөл хэрэгжүүлэгч компанид хүлээлгэлээ.

Усны нөөц горим чанарын төлөв байдлын өөрчлөлтөд байнгын ажиглалт, хяналт, шинжилгээ хийж, хяналт тавих, энгийн болон аюултай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу ангилан ялгаж, дахин боловсруулах болон бусад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Цацраг идэвхт хог хаягдлыг уурхайн талбайд ангилах, ялгах, боловсруулах, аюулгүй булшлах эдгээр үйл ажиллагаатай холбоотойгоор байгаль орчныг нөхөн сэргээх асуудлыг бүрэн хариуцаж гүйцэтгэх мөн байгаль орчныг хамгаалах цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа хөрөнгийг хуульд заасны дагуу тусгайлан байршуулах үүргийг тусгалаа.

Техник-эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодорхойлсон суурь үзүүлэлтүүдийг ашиглаж, төслийн бүх үе шатад байгаль орчны мониторинг, геоэкологийн судалгаа, цацрагийн хяналтыг хэрэгжүүлэхээр тохирлоо.

Төсөл хэрэгжүүлэгч компани нь байгаль орчин нь усны хяналт, мониторингийн үйл ажиллагаанд олон нийтийн төлөөллийн оролцоог хангахаар харилцан тохиролцсон болно.

Энэхүү хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж хэрэгжүүлснээр улс орон нутгийн төсөвт жилд 520 тэрбум, төслийн нийт хугацаанд 17,1 их наяд төгрөг, Үндэсний баялгийн санд жилд 61,5 тэрбум, төслийн нийт хугацаанд 2 их наяд төгрөгийг төвлөрүүлж, 1600 ажлын байрыг шинээр бий болгож, шинэ технологи нутагшуулж, хүхрийн хүчлийн үйлдвэр зэрэг бүтээн байгуулалт хийгдэх боломж бүрдэх болно.

Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж, хөрөнгө оруулалтын орчин сайжирч төсвийн орлого дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, дэвшилтэт технологи, мэдлэг туршлагыг нэвтрүүлж, шинэ төрлийн үйлдвэрийг хөгжүүлэн ажлын байрыг нэмэгдүүлж мэргэшсэн боловсон хүчний нөөц бүрдүүлэх зэрэг нийгэм эдийн засгийн үр өгөөжийг бий болгохоос гадна Монгол Улс стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүн экспортлогч орон болж, улмаар ураны зах зээлийн гол тоглогчдын нэг болох нүүрсхүчлийн хий ялгаруулдаггүй цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэх эхлэл тавигдах болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар болон Орано Майнинг С.А.С компанийн хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхөөр танилцуулж байна. Хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Б.Бейсен:** Учрал сайдад баярлалаа. Байнгын хорооны хуралдаанд оролцох ажлын хэсгийг танилцуулъя. Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Нармандахын Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гүнчинсүрэнгийн Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого төлөвлөлтийн газрын дарга,

Баатарын Мөнхтогтох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын хяналтын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга ирээгүй байна. Туулхангайн Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга ирээгүй байна уу. Зэнээмядарын Батбаяр Усны газрын дарга ирсэн байна. Цэрэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын дарга ирсэн байна. Бямбарагчаагийн Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга ирсэн байна. Гунаажавын Манлайжав Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга ирсэн байна. Энхгэрэлийн Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, Мавагийн Чадраабал Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга ирсэн байна. Сэр-Одын Ган-Очир Ашигт малтмалын газрын тосны газрын Геологи ашиглалтын газрын дарга ирээгүй байна уу. Лхагвасүрэнгийн Жаргалсайхан Шинжлэх ухааны академийн Хими, хими технологийн хүрээлэнгийн захирал ирсэн байна. Бат-Эрдэнийн Хулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Алтангэрэлийн Мандуул Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх, Цагааны Өнөрнасан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын ахлах шинжээч, Санжаагийн Наранцогт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, Лувсаншаравын Наранчимэг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Балжиннямын Гэрлээ “Эрдэнэс Монгол” Компанийн Хууль, эрх зүйн зөвлөлийн дарга, Цэдэнбалжирын Төгсбуян “Эрдэнэс Монгол” компанийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга, Түмэнжаргалын Төрбадрах “Эрдэнэс Монгол” компанийн хамтын ажиллагааны хэлтсийн менежер, Доржбалын Далайжаргал “Мон-Атом” компанийн захирал, Амарсайханы Алтанхундага “Мон-Атом” ХХК-ийн Уул уурхайн ахлах инженер, Дашдаваагийн Сугарсүрэн “Мон-Атом” компанийн Захиргаа удирдлагын албаны дарга, Лхагвын Өнөрбаатар “Эрдэнэс Оюутолгой” ХХК-ийн Геологи, уул уурхайн хэлтсийн ерөнхий менежер, Батцэнгэлийн Баяр-Өлзий “Эрдэнэс Оюутолгой” компанийн Санхүү шинжилгээний хэлтсийн ерөнхий менежер, Цэрэндоржийн Мөнх-Оюунбаатар “Эрдэнэс Оюутолгой” компанийн Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Дашдоржийн Баярхүү Олон улсын харилцааны судлаач, профессор ирсэн байна. Яндагийн Ганболд Монголын мал эмнэлгүүдийн дундын хоршооны зөвлөх, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, академич, профессор ирсэн байна. Норовын Тэгшбаяр Физик ухааны доктор ирсэн байна. Ганбатын Мөнхболд Дотоодын хуулийн зөвлөх ирээгүй байна уу. Баярбатын Батмандах Дотоодын хуулийн зөвлөх ирсэн байна. Зуунайн Шагдарсүрэн Дотоодын хуулийн зөвлөх, Сүхдоржийн Батхүлэг Дотоодын хуулийн зөвлөх, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа.

Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү. 6 гишүүний нэр ирсэн байна. Ганбаатар гишүүнээр тасалъя. Б.Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Эрхэм гишүүд ажлын хэсгийнхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Яах вэ, ер нь бол ажлын хэсэг маань бас маш сайн ажилласан. Нийгэмд гарч ирж байгаа тодорхой эргэлзээг бас нэлээн сайн тайлж байгаа болов уу гэж бодож байгаа. Гэхдээ энэ дээр зүгээр учир дутагдалтай юмнууд бас байна. Ялангуяа мэргэжлийн байгууллагууд бол ор тас чимээгүй байгаа. Мэргэжлийн байгууллагууд мэргэжлийн дүгнэлтүүдээ хэлж байх ёстой. Энэ их нууцлалын түвшинтэй асуудал

явж байгаа асуудал биш. Норовын Тэгшбаяр докторт бол бүр баяр хүргэмээр байгаа юм. Ёстой нөгөө ганц дайчин ганцаарддаггүй гэдэг шиг бүх түвшинд л энийг бас ойлгуулах гээд зүтгэж байх шиг байна. Тэгэхээр би одоо Тэгшбаяр доктортоо бол бас баярлалаа гэж хэлэх гэж байгаа юм. Монгол Улсын эдийн засаг, гадаад хөрөнгө оруулалт, томоохон энэ тэлэлтийг хийх гэж байгаа энэ үйл явдалд бас онцгойлон хувь нэмэр оруулж байгаа хүмүүсийн нэг гэж ойлгож байна.

Мэдээж авч явахаа авна, үлдэх нь үлдэнэ гэдэг шиг байгаль орчны л асуудал. Би сая хэлсэн. Нийгэмд бас тодорхой хэмжээний ойлголтуудыг зайлшгүй өгөх шаардлага байна. Гадна талд нөгөө тэмцэгч нэртэй нөхдүүдийн цацаж байгаа мэдээллүүд, бусад би гэдэг онолчдын явуулж байгаа мессежнүүд гээд бас нэлээн олон юмнууд бий. Гэхдээ мэдээж ажлын хэсэг маань цул байж маш дэлгэрэнгүй сайн хариултуудыг өгч байгаа учраас энэ асуудлууд бол нэг их айхтар түймэр тавьчихгүй хэмжээнд явж байгаа болов уу гэж харж байгаа.

Мэдээж байгаль орчны асуудал. Энэ дээр би хариулт өгөөсэй гэж бодож байна. Нөхөн сэргээлттэй холбоотой асуудлууд бий. Менежментийн төлөвлөгөөтэй холбоотой асуудлууд бий. Тухайн компани маань 100 хувь үүнийгээ яг хариуцахаар байгаа юу. Яг юу гэж орсон бэ. Энийг мэргэжлийнх нь үүднээс маш товч тодорхой хэлээд өгөөч гэж хүсэж байгаа юм. Гэрээнд яг юу гэж туссан гэдэг үг хэллэгээр нь. Ингэж байж бид нар бас тодорхой хэмжээнд энэ байгаль орчин сүйдэх гээд байгаа юм шиг, ус унадаггүй болчих гээд байгаа юм шиг, эргээд одоо Монгол Улсад юу ч үлдэхгүй зүгээр дандаа хохирсон гэдэг, байгаль орчин сүйдсэн гэдэг, тухайн газар орон нутгийн иргэд амьдрах орон нутаггүй болсон гэдэг энэ явуулж байгаа мессежнүүдэд бол зөв зүйтэй хариулт өгнө гэж харж байгаа.

Тэгээд усны агентлаг маань ч гэсэн Батбаяр дарга энэ мэдээллүүд дээрээ бас нэлээн сайн ялангуяа энэ устай холбоотой асуудлууд дээр мэдээллүүдийг гадна тал руугаа бас нэлээн сайн мэдээлж, шинжлэх ухааны үндэслэлтэй, зөв ус болгоныг уудаг зүйл биш шүү гэдгийг бас сайн танилцуулж хэлж байхгүй бол энэ чинь ахуйн ус, ундны ус, үйлдвэрлэлийн усаа ч ялгахгүй байгаа хүмүүс орж ирээд л би би гэдэг байдлаар хандаж байна шүү дээ. Тэгээд энэ дээр бас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, мөн холбогдох хүмүүс маань яг гэрээнд орсон үг үсгээр нь маш тодорхой хэлээд өгөөч гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

**Б.Бейсен:** Хэн хариулах вэ. 5 номер хариулъя. 5 номерын микрофон өгье.

**Ц.Уранчимэг:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын газрын дарга Уранчимэг байна. Сайд үнэхээр чухал асуудал бас асуулаа. Манай сайд байсан хүн. Яг яах аргагүй байгаль орчны нөхөн сэргээлт, тэр тусмаа яг энэ төсөл маань шинээр яг Цөмийн энергийн хуультай холбоотой шинэ ийм байгаль орчны нөхөн сэргээлтийн асуудал яг энэ дээр хөндөгдөж байгаа. Тэгэхээр байгаль орчныг хамгаалах 8 дугаар бүлэг дээр, гэрээний 8 дугаар бүлэг дээр бол маш тодорхой оруулсан байгаа. Энэ дээр бол яг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт мониторинг хийх ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч бүрэн хариуцна гэдэг заалтыг оруулсан. Мөн нэмж 8.3 дээр бол байгальд орчинд учирсан хохирлыг арилгах заалтыг төсөл хэрэгжүүлэгч компани нь төсөл хэрэгжүүлэх бүх үе шатад хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулсан болох нь үнэлгээгээр тогтоогдвол байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөллийг арилгах болон алдагдсан экологийн тэнцлийг мөн байгалийн нөөцийг сэргээхийн тулд сөрөг нөлөөллийг



байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд туссан зорилт түвшинд хүртэл бууруулах арга хэмжээг авна гэдэг ийм тодорхой заалтуудыг бас оруулсан байгаа.

Одоо яг батлагдах гээд явж байгаа урьдчилсан ТЭЗҮ дээр яг энэ нөхөн сэргээлттэй холбоотой зардал тодорхой туссан байгаа. Тэгэхээр энэ нөхөн сэргээлт хаалтын гэрээ дээр бол ураныг уусган олборлох боловсруулах үйлдвэртэй холбоотой нөхөн сэргээлтийн газрын гадарга цооногийн, мөн ус давхаргын гэж 3 ангиллаар нөхөн сэргээлтийн ангиллын бол шинээр оруулж өгсөн байгаа. Тэгэхээр ашиглалтын үед нөхөн сэргээлтийн ажлын байнгын гүйцэтгэлийг бол энэ 3 аргаар бол хийж явна. Энэ уст үеийн нөхөн сэргээлт гэдэг бас шинэ нэр томъёо яг энэ ТЭЗҮ дээр орж ирж байгаа. Энэ яг технологитой холбоотой. Тэгэхээр энэ нөхөн сэргээлтийн гол зорилго нь бол яг уул уурхайн үйл ажиллагаа дууссаны дараа ус давхаргын усыг анхны түвшинд байлгахад нь чиглэж технологийн нөхөн сэргээлтийг хийнэ. Тэгэхээр яг энэ анхны түвшинд нь байлгана гэдэг ойлголтыг байлгахын тулд ТЭЗҮ-д байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт дээр яг одоо байгаа анхны нөхцөлийн бүх гидрогеологийн байгалийн, мөн бүх суурь үзүүлэлтүүдийг бол бид нар яг энэ хавсралтаар нэмэлтээр оруулж өгч ингэж ажиллаж байгаа.

Тэгээд байгаль орчны хаалтын нөхөн сэргээлтийн зардалд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, уул уурхайн хаалтын зардалд одоо байгаагаар бол 329 сая долларыг зарцуулахаар төлөвлөн ТЭЗҮ-д бол тусгаж байгаа. Тэгэхээр ТЭЗҮ батлагдсаны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг батална. Тэр дээр бол байгаль орчны менежментийн жил болгоны төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, цацрагийн төлөвлөгөө, эрүүл мэнд, нийгмийн бүс нутгийн нөлөөллийн үнэлгээг бүгдийг нь тусгаж оруулахаар тусгаад, гэрээнд бас энэ бүх заалтуудыг оруулсан байгаа.

**Б.Бейсен:** Чинбүрэн гишүүн асуулт асууя.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Бас ч үгүй бас нэлээн цаг хугацаа орсон. Бараг 30 гаруй жилийн үйл ажиллагаа явагдаж, өнөөдөр бид одоо Засгийн газар 2 улсын хооронд энэ гэрээ хийгдэх гэж байгаа энэ мөчид бас цуглаж энэ гэрээ хэлэлцээрийн гэрээний талаар ярьж байна.

Би 2020-2024 оны парламентад бас Монгол Францын найрамдлын бүлгийн даргын хувьд ажиллаж байх хугацаанд бас нэлээдгүй мэдээлэл бас энэ төсөлтэй холбоотой авч байсан. Тэр ч утгаараа бас Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчилж, дараагаар нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх бас Франц улсад айлчлахад хүртэл цуг оролцож байсан. Тэгээд 2 асуулт байна.

Нэг дэх асуулт нь бол энэ 12 дугаар бүлэгтэй холбоотой Цөмийн энергийн комиссын дарга Манлайжав даргаас асуух гэж байгаа юм. 12.3-д инновацын хөтөлбөр гэж байгаа. Төсөл хэрэгжүүлэгч компани нийгмийн хариуцлагын хүрээнд төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор өөрийн зардлаар цацраг идэвхт ашигт малтмал хийх, олборлох буюу ашиглах, боловсруулах чиглэлээр сургалт судалгаа гэж. Тэгэхээр би энэ дээр бол цөмийн энергийг энхийн чиглэлд ашигладаг гол салбар бол хавдар судлал байдаг учраас яг энэ хавдрын туяа эмчилгээ, хавдрын эмчилгээнд цацраг идэвхтэй бодисыг судлах шинжлэх энэ

судалгааны ажилд дэмжлэг оруулна гэж би ойлгож байгаа. Энэ ойлголт зөв үү. Энэ хүрээнд тэгж ойлгож болох уу гэж нэг дэх асуулт.

2 дахь асуулт. Би “Мон-Атом” компанийн удирдлагаас бас асуумаар байна. Ер нь орон нутгийн иргэдийн хандлага, ерөнхий байдал төлөв, ойлголт яг ямар түвшинд өнөөдөр байгааг нэг тодорхой хэлж өгөөч. Баярлалаа.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ.1 номер хариулъя. Бас өөрсдийгөө танилцуулж байгаад хариулж байгаарай.

**Г.Манлайжав:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Цөмийн нийгмийн комиссын нарийн бичгийн дарга Манлайжав. Таны хэлж байгаатай бол бид нарт 100 хувь санал нэг байгаа. Франц улс бол ер нь энэ цөмийн салбарын хамгийн гол пионерууд тэр нөгөө бүхэл үүсгэн байгуулсан, нээсэн бүх улсууд бол энэ Францтай холбоотой. Одоо ч гэсэн цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор хамгийн их 70 гаруй хувьтай эрчим хүчээ үйлдвэрлэж байгаа. Дээр нь энэ цөмийн технологийн чиглэлээр их өндөр хөгжилтэй. Бид нар бол Франц улстай, тэр тусмаа энэ салбарынхаа чиглэлд бол хамтын ажиллагааг нэлээд хөгжүүлж яваа. Гэхдээ хамтын ажиллагаа хөгжүүлж байгаа чиглэлүүд маань эргээд буцаад хэрэгжилтээ хангахад дандаа хөрөнгө мөнгө, санхүүжилттэй холбоотой байдаг. Манай энэ “Бадрах Энержи” компанийн энэ төслүүд ингээд хөдлөхөд бид нарын өмнө байгуулсан хамтын ажиллагааны ажлууд бол эрчимжинэ гэж ойлгож байгаа. Тэр дундаа бид нар Францын цөмийн энергийн коменсертай бол боловсон хүчин бэлтгэх чиглэлээр зөвхөн ганцхан энэ уул уурхайтай энэ ураны цацрагт ашигт малтмалын технологитой холбоотой биш, геологийн асуудлууд бий, байгаль орчны асуудлууд, инженерчлэлийн асуудлууд, тэр дундаа бас цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлаар нэлээд олон хүнийг бол бэлтгэхээр төлөвлөж хамтарсан төлөвлөгөө баталсан, гарын үсэг зурсан. Энэ ажиллагаа бол эрчимжих байх гэж бодож байна.

Чинбүрэн гишүүний санаа зовж байгаа ер нь Хавдар судлалын төвтэй холбоотой асуудал дээр бид нар нэг ёсондоо ураныг олборлож байгаа. Урантай холбоотой энэ бизнест орж байгаа анхдагч орны хувьд эргээд бол бид нар энэ цөмийн эрчим хүчийг ашиглах, тэр дундаа бас нөгөө цөмийн изотоп үйлдвэрлэдэг тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх тал дээр бас Франц улстай их хамтарч ажиллана. Бид нар олон улсын атомын агентлагийн гишүүн орны хувьд Франц ч гэсэн бас энэ байгууллагын гишүүн. Бид нар бас өмнө нь ярьж байсан асуудлууд бий. Цөмийн технологи тэрэндээ бас нөгөө судалгаа шинжилгээний тоног төхөөрөмж, лабораторийг байгуулах, энэ хавдартай холбоотой изотопын асуудлуудыг бас үйлдвэрлэх чиглэлээр ОУБ-аар дамжуулаад Франц улсын өгдөг татвар дэмжлэгийн хүрээнд энэ асуудлыг бас зохицуулах бололцоо байгаа гэдэгт бол бид нар итгэж байна. Бид нар энэ чиглэлд онцгой анхаарч ажиллана. Баярлалаа.

**Б.Бейсен:** 2 Номер хариулъя.

**Д.Далайжаргал:** Баярлалаа. “Мон-Атом” компанийн захирал Далайжаргал байна. Орано группийн нэг салбар нь анагаах ухааны салбар шүү дээ. Цөмийн эрчим хүчээр технологи ашиглаад хавдрыг арилгах тэр чиглэл нь Ораногийн 1 том салбар шүү дээ. Тэгээд Орано чинь өөрөө Францдаа болон Европтоо энэ чиглэлийн тоног төхөөрөмжүүдийг хийж, зарж байгаа. Тэгэхээр 2 дугаарт өчигдөр

Ундраа гишүүн гишүүн асууж байсан. Тэр их чухал асуулт. 2010 онд Монгол Улсын Засгийн газар Францын Засгийн газартай цөмийн энергийн салбарт хамтран ажиллах гэрээ байгуулсан. Засгийн газар хоорондын. Энэ гэрээний 1 чухал заалт нь цөмийн энергийн салбарт анагаах ухаан, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллана гэсэн заалт байгаа юм.

2 дугаар асуудал орон нутгийн хамтын ажиллагаа. Орон нутгийн хамтын ажиллагаа хэл амаа ололцоод, өнөөдөр ямар нэгэн асуудал байхгүй гэдгийг би энд хариуцлагатайгаар хэлье. Сүүлийн 15 жил бол ямар нэгэн асуудал байхгүй. 2 хүчин зүйл нөлөөлсөн.

1 дүгээрт бид нар энэ төслийг олон нийтэд таниулах, ялангуяа нутгийн иргэдэд таниулах арга хэмжээг өнгөрсөн 4 жилийн хугацаанд үе шаттай авсан. Зөвхөн өнгөрсөн 3 жилийн хугацаанд 1680 хүн төсөл дээр очиж танилцсан байгаа. Өнгөрсөн онд гэхэд 680 хүн төслийг очиж үзсэн. Улаанбадрах сум өөрөө 1600 хүнтэй. Тэгэхээр ихэнх нь бол орон нутгийн иргэд очиж үзсэн.

2 дугаарт хамтын ажиллагааны зөвлөл гээд Улаанбадрах сум, Зүүнбаян сум, хөрөнгө оруулагч тал, малчид гэсэн ийм 4 хамтын ажиллагааны зөвлөл байгаа. Сүүлийн 4 жилд жил болгон 1 тэрбум төгрөгийг орон нутагт энэ 2 сумд өгдөг. 600 мянгыг нь болохоор Улаанбадрах суманд, 400-г нь Зүүнбаян сумд өгдөг. Хоёрхон асуудал хэлэлцдэг. Энэ мөнгийг ямар төсөлд зарцуулах вэ, 2 дугаарт орон нутгаас малчдаас ирсэн аливаа санал асуултад хариулт өгдөг ийм хамтын ажиллагааны зөвлөл байгаа юм. Баярлалаа.

**Б.Бейсен:** Чинбүрэн гишүүн тодруулъя.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Тэгэхээр би Учрал сайдад бас энэ төсөл, гэрээ батлагдаад ажиллахлаар бас Засгийн газарт зориуд бас хэлье гэж бодож байгаа юм. Тэгэхээр түрүүн бас хэллээ. Далай захирал хэлж байна. Орано Майнинг өөрөө хажуудаа яг цөмийн энергийг эрүүл мэндийн шинжлэх ухаанд ашиглах ийм том лаборатори, сургалтын шинжлэх ухааны төвтэй. Тэгэхээр энд бас бид бас онцгой анхаарч, бид бүгдийг нөгөө Ерөнхийлөгчийн айлчлалаар Францад айлчлахад бүр очиж бид өөрснөө үзсэн. Нүдээрээ үзсэн. Тэгэхээр энэ хавдрын эмчилгээ нь ялангуяа изотоп гэдгийг чинь яг хавдрыг нь өөрийн таньдаг болгоод наагаад, тэгээд изотоп нь очоод тэр хавдрыг чинь устгачихдаг болчихсон. Тийм учраас энэ чиглэлд боловсон хүчин бэлтгэх, хамтарсан судалгаа хийх чиглэлийг та санаандаа аваарай. Тэгээд энэ хэрэгжээд эхлэхээр тэр инновац, технологи хөтөлбөрийнхөө хүрээнд 12 дугаар зүйлтэй холбоотойгоор хавдрын энэ чиглэлийн сургалтыг хийхэд бүгдээрээ хамтарч ажиллая гэж хэлье.

**Б.Бейсен:** Уянга гишүүн асуулт асууя.

**Б.Уянга:** Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Байгаль орчны байнгын хорооны гишүүддээ хандаад нэг зүйлийг хэлэхэд нөгөө Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам дээр ажиллаж байхад нөгөө Оюутолгойн гэрээтэй холбоотой асуудлууд их орж ирж байсан юм. Тэгээд яг одоо сая энэ Ораногийн гэрээг гишүүдэд өгөх үеэр нэлээн тийм харьцуулж харж үзсэн. Тэгэхэд бол их олон заалтууд нь сайжирч орж ирсэн байгаад бол бас ажлын хэсгийнхэнд талархалтай хандаж байгаа юм. Зөндөө л олон зүйлийг нь ярьж л байгаа.

Тэгэхдээ 1 зүйл нь болохоороо Оюутолгойн гэрээг 2009 онд байгуулагдахдаа нэмэлт, өөрчлөлт оруулах тийм боломжийг нь хаагаад, 2039 он хүртэл бид нар ерөөсөө нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрсдийнх нь саналыг зөвшилцөх тийм боломжгүй болгочихсон байхгүй юу. Тэгтэл энэ гэрээ дээр байгаа нэг том давуу заалт нь юу вэ гэхээр хэрвээ манай хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт орох юм бол, тэгээд 2 тал хоёулаа зөвшөөрөх юм бол гэрээнд өөрчлөлтийг оруулж болно гэж зүйл заалтаар оруулж өгсөн байгааг бол маш их дэмжиж байгаа. Тэгэхээр бас энэ гэрээнд зөвшилцөж байгаа ажлын хэсэгт их чадварлаг залуус орж ажилласан байна гэж харж байна. Бас энэ залуусынхаа багийг алдахгүйгээр Учрал сайд тэр бусад хэлцлүүдийг бас хийхэд ашиглавал их зүйтэй байх гэж бодож байна.

Тэгээд гэрээний заалтуудыг нарийн уншиж байхад 2 зүйлийг л асуучихъя гэж бодогдоод болохгүй байна. Тэр нь болохоороо яах вэ, уурхайн хаалт нөхөн сэргээлттэй холбоотой. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хүн байна. Яг энэ гэрээний заалт 5.7а-ийн 3 дээр болохоороо уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн асуудал Бат-Эрдэнэ гишүүн түрүүн бас хөндсөн. Тэгэхээр энэ бол нэлээн чухал. Энэ бол яг Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.14-д заасан журмын дагуу явагддаг. Тэгэхээр энэ журмын дагуу нөхөн сэргээлтийнх нь төлбөрийг авах ёстой, байршуулах ёстой биш үү. Жил болгон хуваагаад ижил хэмжээгээр байршуулна гэдэг нь хэрвээ журам маань арай өөрөөр гарах юм бол, өөрчлөгдөх юм бол тэр бүртээ нэгэнт гэрээндээ өөрчлөлт оруулах эрхтэй юм чинь гэрээнд өөрчлөлт оруулаад явна гэж харж байгаа юу. Яг үүнийхээ үйлчлэлийг тайлбарлаад өгвөл хэрэгтэй байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхан.

Хоёрдугаарх нь болохоороо 8.1а дээр энэ төсөл хэрэгжүүлэгч компани энэ уурхайн үйл ажиллагааг явуулахдаа Монгол Улсын ямар ямар хуулиудыг дагаж мөрдөх вэ гэж бол заасан байгаа. Энэ дээр Газрын хэвлийн тухай хуу байдаггүй. Тэгэхээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамныхан Газрын хэвлийн тухай хуулиа оруулах байсан биш үү. Газрын хэвлийн тухай хууль дээр бол сорчлон ашиглахтай холбоотой асуудлыг хөндсөн байдаг. Байгаль орчны асуудлууд бас туссан байдаг. Тэгээд яг энэ хуулиасаа Ашигт малтмалын тухай хууль өөрөө салбарласан байдаг учраас бүгдийг нь оруулах ёстой байсан биш үү гээд ийм 2 хуулийн заалтыг оруулаад асууя. Энэ дээрээ хариулт авъя. Тэгээд ажлын хэсгийнхэнд дахин бол талархал илэрхийлмээр байна. Тэгээд цааш цаашдаа Эрдэнэс Монгол олон хөрөнгө оруулалтын гэрээ дээр ажиллах байх гэж найдаж байна.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 5 номерын микрофон.

**Г.Намчинсүрэн:** Уянга гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн. Ер нь бол уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн асуудлыг өмнө нь Ашигт малтмалын хуульд заасны дагуу хуучин нэрээр Уурхай хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан нөхөн сэргээлт хаалтын журмын хүрээнд л зохицуулж явсан. Тэгэхдээ энэ төсөл дээр бол Засгийн газрын зүгээс онцгой анхаарал хандуулаад, сая 11 сарын 20-нд орсон Цөмийн энергийн хуулийн өөрчлөлт дээр хаалт, нөхөн сэргээлтийн баталгааг авах асуудлыг хуульчилж зааж өгсөн.

Мөн дээрээс нь байгаль орчны нөгөө менежментийн төлөвлөгөөг 5 жил тутам тодотгох, хаалт, нөхөн сэргээлтийн асуудлыг бол уурхай хаагдахаас өмнө 5 жилийн өмнө батлуулсан байх шаардлагыг бол хуульд зааж өгсөн. Зүгээр яг ордыг иж бүрэн ашиглах асуудал дээр хэлэлцээрийн явцад бид нар нэлээн шахаж

ажилласан л даа. Ордын ашиглалтын нөөцийг багасгасан тохиолдолд тэр хэмжээнд Засгийн газарт нөхөн төлбөр төлүүлнэ ч гэдэг юм уу. Нэлээн шахаж ажилласныхаа үр дүнд айлын талаасаа ордыг иж бүрэн ашиглах асуудлыг эрмэлзэнэ гэдгээр оруулж ирсэн.

Нөгөөтээгүүр энэ ордын нөөц маань өөрөө ашиглалтын нөөц маань өсөх боломж бүрдчихсэн байгаа. Энэ маань ямар асуудлаас бүрдсэн бэ гэхээр ордын ТЭЗҮ бол ордын тухайн ураны ислийн борлуулалтын үнэлгээг 52 ам.доллороор гэж анх орж ирсэн. Сая хэлцэл хийж яваад ТЭЗҮ дээр нь шинжээчдийн хэсэг гарч ажиллаад, мөн энэ эдийн засгийн чиглэлээр ажлын хэсэг гарч ажилласны үр дүнд 75 ам.доллороор ТЭЗҮ дээрээ борлуулалтын орлогыг төлөвлөж орж ирж байгаа. Тэгэхээр бид нар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл дээр үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх асуудлыг бол төсөл хэрэгжүүлэгч талд тавих боломж бүрдсэн л гэж үзэж байгаа юм.

**Б.Бейсен:** Уянга гишүүн тодруулъя.

**Б.Уянга:** Ойлголоо. Газрын аюулын тухай хууль дээрээ хуулиа оруулахаар бас яриад үзээрэй. 8.1 дүгээр заалт байгаа шүү. Нэг зүйлийг бас хэлэх гэсэн юм. Сая хэдэн гишүүдийн төлөөлөл Катко Казакстаны уурхай дээр очиж ажиллахад “Мон Атом”-ын Бадрах Энержигийн 2 Монгол геологич газар дээр нь ажиллаж байсан. Тэгээд тэрийг бол нэлээн сайшаалтай хүлээж авсан шүү. Тэгээд бид нар 90 хувийг нь Монгол ажилчид ашиглалтын үедээ оруулна гэж ярьж байгаа. Тэгэхээр цаашдаа ер нь ямар төлөвлөгөөтэй байна вэ. 4 жилийнхээ бэлтгэл ажлынхаа хүрээнд хэчнээн Монгол мэргэжилтнийг бэлтгэх төлөвлөгөө гаргасан байгаа вэ. Энийгээ үргэлжлүүлээрэй.

**Б.Бейсен:** 2 номер хариулъя.

**Д.Дайлжаргал:** Тийм ээ. Өнгөрсөн хугацаанд бид нар ярьж байгаад “Мон Атом”-ын хүрээнд ярьж байгаад 2, 2 хүнийг 6, 6 сараар ажиллуулж байгаа. Ер нь 2003 оноос хойш хүмүүс бэлдэж эхэлсэн. Нийтдээ 77 хүнийг 268 удаагийн сургалтад хамруулаад, газар дор уусган олборлох технологид сургачихсан байгаа. 53 багшийг яг энэ чиглэлээр мэргэжил дээшлүүлээд сургачихсан. Орано групп дээр 2 хүн ажиллаж байгаа. Калтко дээр 2 хүн, энийгээ 2, 2-оор нэмэгдээд ажиллана. Үндсэндээ яг төсөл эхлээд 2028 онд эхлэхэд Монгол ажилд гол ажлыг нь Монголчууд хийж нугалах юм.

**Б.Бейсен:** Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

**Ж.Батжаргал:** Хөрөнгө оруулалтын гэрээний өгөөж, төсөв хөрөнгөтэй холбоотой асуудлыг түрүүн Төсвийн байнгын хороо дээр их тодорхой ярьчихсан. Одоо энэ Байнгын хороо дээр байгаль орчин, уурхайн хаалт, нөхөн сэргээлттэй холбоотой асуудлыг жоохон тодруулах юмнууд байгаад байх шиг байна. Шинэ ч юм биш л юм байна л даа. 20 хэдэн жил үйл ажиллагаа явуулчихсан, тэгээд туршилтын үйлдвэрлэл хийчихсэн, 10 орчим тонн бүтээгдэхүүн гаргачихсан ийм юм байна. Тэгэхээр байгаль орчны нарийвчилсан үнэлгээ одоо мөрдөгдөж явсан байх ёстой. Энэ хугацаанд. Тэрүүгээр дурдагдсан асуудлууд ер нь хэрхэн хангагдаж явсан юм бэ. Ямар зардал яг тэр үнэлгээг хангах үүдэнд чиглүүлсэн бэ гэдэг асуудал өөрөө чухал байгаад байгаа юм 1.

2 дахь зүйл үүний гол орц хэд хэдэн орцууд байгаад байх шиг байна. Энэ төслийг хэрэгжүүлэхэд.

1 дүгээрт ус дээр нэлээн тулгуурлаж бүтээгдэхүүнээ гаргаж ирэх нь гэж. Үндсэндээ доор байгаа жоохон уранаа дээш нь хүүлэх гээд байгаа юм уу гэмээр юм уу. Юу гэж хэлмээр юм. Хүхрийнхээ хүчилтэй холих гээд байгаа юм уу, үгүй ээ яах гээд байгаа юм. Тэгээд ус хэрэглэнэ гээд байгаа юм. Тэр нэлээн гол зүйл байгаад байна. Тэгэхээр одоо ярихаараа хүний ундны усанд гэдэг юм уу, үйлдвэрлэлийн зориулалттай усанд хамаагүй ээ. Угаасаа урантайгаа нийлчихсэн усыг бид ашиглаж байгаа гэх нь холгүй юм яриад, магад ч үгүй ус бохирдуулсны төлбөр төлөхгүй байгаад байх магадлал өндөртэй юм ярьцгаагаад байна. Тэгэхээр энэ гэрээ дотор ер нь энэ талын асуудал яаж тусаж оров гэдэг асуудал байгаад байна.

Дараагийн зүйл энэ том төслийг хэдүүлээ дагуулаад бас нэг үндэсний хэмжээний шинэ салбаруудын хөгжлийг бий болгох хэрэгтэй байгаад байна л даа. Тэр хүхрийн хүчил гэж юм зайлшгүй шахдаг л ёстой юм бол тэр чинь зэсийнхээ үйлдвэрлэлээс гараад ирдэг юм гээ биз дээ. Тэгэхээр тэр хэдий хэмжээний хүчин чадалтай үйлдвэрийг бид хэдий хугацаанд барихаар ер нь төсөөлж байгаа юм байна уу. Тэгж байж энэ дотоодын үйлдвэрүүдийн кластер хөгжил тэрүүгээр дамжиж нэг том төслийг хөдөлгөхөд дахиад нэг шинэ салбарыг бий болгож авах үр өгөөж дээшлүүлэх асуудал дээр ер нь юу тооцож хараад байна. Энэ талаар та хэдээс энэ гэрээ хэлцлүүд дээр ер нь ямархуу мэдээлэл юу орсон гэдэг нэг ийм зүйл байна гэж.

Дараагийн зүйл энэ чинь 3 нэгж талбар дээр явагдах үйл ажиллагаа юм билээ. Тэгэхээр энэ гүний уусган баяжуулах аргаар явах гээд байгаа юм байна гэж би ингэж л ойлгоод байгаа. Тэгэхээр уурхайн хаалт буюу нөхөн сэргээлт төсөл хэрэгжээд дууссаны дараа явах ч тухай ойлголт биш л юм байна л даа. Тухайн нэгж талбар доторх цооногуудын ашиглалттайгаа уялдаад түрүү талын цооногуудаа буцаагаад хаалт ... /минут дуусав/

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 2 номер хариулъя.

**Д.Далайжаргал:** Би танин мэдэхүй маш энгийн юм ярья. Говь, тал хээрийн бүсэд уран газрын гүн 140-170 метрт элсэн дотор наалдчихсан байгаа. Яг нарийн дээр 10 хувийн ус, 20 хувийн элс, хайрга гэсэн ийм бүтцэд байгаа. Тэгэхээр 2 хувийн саармагжуулсан хүхрийн хүчилтэй усыг доошоо ус руу, говийн ус руу шахна. Өөрөөр хэлбэл 100 литр усанд 2 литр хүхрийн хүчил хийсэн гэдгийг шахаад наалдахаар хүхрийн хүчилтэй усанд элсэн дэх уран нь хайлаад уусаж байгаа. Тэгэхээр урантай усыг нь гаргаж аваад ураныг нь салгаж аваад, шингэн биетээр нь салгаж аваад буцаад тэр усаа ахиад шахна. Эндээс 2 зүйл гарч байгаа. Говийн бүсэд өөрөөр хэлбэл доор их хэмжээний их хэмжээний ус байна гэсэн ойлголт байхгүй. 2 дугаарт 1 хэрэглэсэн усаа дахиж шахдаг ийм технологи. Энэ газар доор уусган холболт технологи гэж байгаа. 15см-ын диаметртэй трубануудыг 300 орчим, 400 орчим трубаг доошоо шахаж явуулна. Таны хэлдэг үнэн. 1, 1-ээр нь хийж явчхаад тэр нь ашиглагдаад дуусангуут трубануудаа салгаж аваад, тэгээд байгаль орчныг төсөл явах хугацаандаа өөрөө тэрийгээ нөхөн сэргээгдэх ийм процесс байгаа.

**Б.Бейсен:** 3 номер. Тэгшбаяр хариулъя.

**Н.Тэгшбаяр:** Доктор Тэгшбаяр байна. Таны асуултад бас хариулъя. Та бас зөв ойлгосон байна. 170-180 орчим метрт яг олборлохуйц хэмжээний урантай тэр орчны ус бол өөрөө угаасаа цацрагийн хувьд ч хоруу чанартай байгаа. Химийн хувьд ч хоруу чанартай байгаа. Тэр усыг бол уран газар доор уусган баяжуулах аргаар уран олборлохоос өөр юунд ч ашиглах боломжгүй. Тийм учраас энэ газар доор уусган баяжуулах аргыг бол дэлхий дээр нийт уран олборлолтын нөгөө 56-60 орчим хувийг нь бол энэ аргаар олборлож байгаа. Энэ бол шинэ технологи биш. Дэлхийд ашиглагдаад ингээд туршигдсан ийм технологи байгаа. Ийм л юм байгаа.

Усны тухайд, нөхөн сэргээлтийн тухайд бол ямар PH-тэй орчин байсан тэр PH-тэй орчин руу аваачих тухай асуудал байгаа. Энэ дээр бол байгалийн аргаар нь бас өөр бусад аргаар PH-руу нь аваачих боломжтой.

**Б.Бейсен:** 4 номер хариулъя.

**З.Батбаяр:** Усны тухай асуудал энэ гэрээний нэг онцлог байгаа. 8 дугаар зүйл дээр байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал байгаа. 8.4 дээр ус ашиглах гээд тусгай бүлэг гэх юм уу, хэсэг болж орсон байгаа. Энэ дээр 12 зүйл байгаа. Би эндээс эхнийхийг нь та бүхэнд яг уншаад үзүүлчихье.

Төсөл хэрэгжүүлэгч компанийн төсөл хэрэгжихээс өмнөх үеийн орон нутаг, нөлөөллийн бүсэд амьдардаг иргэд, мал, амьтны ундны болон ахуйн хэрэглээний ус, хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглах усны нөөц, чанарт нөлөөлөхгүй байх шаардлагыг ханган ажиллах үүрэгтэй гэж. Өөрөөр хэлбэл 8.4а дээрээ үндсэн зорилгыг нь тогтоогоод өгчихсөн байж байгаа. Эндээс сая гишүүний асуусан асуултаас харахад Монгол Улсад 4 янзын усны төлбөр байгаагаас энэ төсөлтэй холбоотойгоор ус ашигласны болон ус бохирдуулсны төлбөр яригдана. Ус ашигласны төлбөр нь одоогийн Зөөвч-Овоо, Дулаан-Уул гэдэг бүс нутагт 2 орд газрын доорх усны орд газар нээгдсэний усны хэмжээ нь усны нөөцийн зөвлөлөөр батлагдсанаар 33 литр секунд байгаа. Боломжит ашиглах нөөц нь гэсэн үг. ТЭЗҮ-д дурдагдсан ёсоор усны хэрэглэх хэмжээ нь 17 литр секунд байж байгаа. Тэгэхээр усны нөөцийн хувьд бол хангалттай, хүрэхээр гэсэн үг. Дээр нь саяын өмнө хариулсан хүмүүсийн хэлдгээр ус ашиглалтын яг мэдээж үйл ажиллагаа явах үед яг тодорхой хувь нь гарна. Ер нь бол урьдчилан таамаглахад 90-95 хувьтайгаар усны дахин ашиглалт явах учраас нөхөн сэлбэж байгаа дээр нь ч гэсэн төлбөрөө тооцоод явчихна. Нэгэнт гэрээ дээр ярьж байгаа учраас гэрээний 8.4ж гэдэг дээр төсөл хэрэгжүүлэгч компани нь Усны тухай болон байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээний үндсэн дээр ашиглана гэдэг үг маань усны газраас жил болгон ус ашигласны дүгнэлт, улирал болгон хаягдал усны дүгнэлтийг буюу ус бохирдуулсны төлбөрийг нь тооцоод явна. Хаягдал усны төлбөрийг хэзээ тооцож эхлэх вэ гэхээр байгальд ямар нэгэн байдлаар бохир ус хаягдал гэж хэлье.

Хаягдал ус нийлүүлсэн тохиолдолд тэр хаягдал усны найрлагаас нь хамаараад Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу төлбөрөө төлөөд явна. Энэ гэрээ дээр байгаль орчны тэр дундаа усны асуудлыг тогтворжуулахгүй гэсэн учраас устай холбоотой ямар нэгэн асуудал гарах юм бол энэ 30 жилийн хугацаанд тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, заавар, стандартын дагуу асуудлыг шийдээд явна гэж.

Мөн гэрээний 8.4к дээр дээр биччихсэн байж байгаа нэг зүйл байгаа. Тэрийг та бүхэн маань бас хараасай гэж. Энэ бол мониторингийн цооногийн тухай асуудал байгаа. Оюутолгой, бусад газруудад бид нар мониторингийн цооногуудыг байрлуулсан нэгдсэн сүлжээ гээд 300-аад цооногтой байж байгаа. Гэхдээ энэ дээр зөвхөн мониторингийн цооног дээр зөвхөн газрын доорх усны түвшний өөрчлөлтийг хэмжихээс гадна, нөлөөллийн бүсэд байгаа айлын ундны зориулалтаар ашиглаж байгаа, малын зориулалтаар ашиглаж байгаа худгийн дэргэд мониторингийн цооногийг байрлуулаад тэр цооног дээрээсээ чанарын хяналтыг давхар тавьж эхлэх юм.

Тийм учраас энд үйл ажиллагаа явсан, яваагүйгээс огт үл хамаараад мониторингийн цооногуудаараа дамжаад чанарын хяналтуудыг хийж эхэлнэ. Мониторингийн цооногууд нь гэрээнд дурдсанаар онлайн буюу бид усны газар дээрээс Улаанбаатар хотоос хяналт тавих ийм боломжтой байж байгаа юм.

Худгийн тухай. Нийт ямар худаг байгаа, хэдэн худаг ямар нөлөөлөл байгаа вэ гэдэг дээр манай химийн хүрээлэнгийн захирал хариулна.

**Б.Бейсен:** 5 номер хариулъя.

**Л.Жаргалсайхан:** Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Жаргалсайхан байна. Энэ Бадрах Энержи компани 2021 онд туршилтын олборлолт хийсэн. Тэгэхээр энэ олборлолтын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг 2015 онд хийгээд, 2021 онд нэмэлт тодотгол хийсэн байгаа. Засгийн газраас Шинжлэх ухааны академид үүрэг даалгавар өгсний дагуу бид нар яг энэ туршилтын олборлолт эхлэхийн өмнө Академиас ажлын хэсэг гарч, бид нар мониторингийг хөрс, ус, тэгээд цацраг, ургамал, малын мах, сүү гэсэн энэ чиглэлүүдээр бол мониторингийг хийсэн. Тэгээд одоо энэ маань 2023, 2024 гээд энэ 2025 онд гээд ингээд үргэлжлээд явна. Тэгэхээр бид нар бол энэ орчны туршилт эхлэхээс өмнөх суурь нөхцөл, туршилт явагдсанаас хойш ямар өөрчлөлт гарсан гэдэг судалгааг бол бид нар ингээд жил болгон хийгээд явж байгаа гэж та бүхэн ойлгож болно.

Тэгэхээр ер нь бол бид нар газрын доорх ус бол хамгийн их яригдаж байгаа эмзэг сэдэв байгаа. Тэгэхээр бид нар энэ судалгаагаа бол газрын доорх усны судалгааг 4 түвшинд хийсэн байгаа.

Хамгийн эхнийх нь бол яг малчдын худаг, үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээгээр ашигладаг 2-60 метрийн гүнд байгаа уст эх үүсвэрүүд, тэрний дараа бол яг нөгөө олборлолт явуулахын дээд уст үе буюу 22-110 метрийн уст үеийн усны шинж чанар, тэгээд дараа нь яг 120-170 метрт олборлолт явагдах хүдэр агуулсан ус давхаргын судалгаа, тэгээд дараа нь тэрний доод талын 176-182км-ийн доодох усны юуг бол судалсан. Тэгээд энэ юугаар ер нь ямар өөрчлөлт олборлолт хийснээрээ гарсан байсан бэ гэхээр мэдээжийн хэрэг хүхрийн хүчил шахаж байгаа учраас PH бол буурч 2,6-4 болж буурсан байсан. Сульфатын агууламж хүхрийн хүчлийн сульфаттай холбоотойгоор 4-20 дахин нэмэгдсэн. Мөн лантан, итри, никель, кофел, хүнцэл гэсэн ийм хүхрийн хүчилд уусдаг элементүүдийн агууламж бас нэмэгдсэн байсан. Мэдээжийн хэрэг ураны агууламж бол 12-7300 дахин бол нэмэгдсэн ийм юунууд гарсан байгаа.



Тэгээд ер нь бол бид нарын энэ хийсэн мониторингийн судалгааны үр дүн бол нөгөө ТЭЗҮ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд суурь нөхцөл болж ороод, тэгээд энэ үр дүнг явцын дунд хийх нөхөн сэргээлт болон хаалтын дараах нөхөн сэргээлтийн суурь үзүүлэлт болж, энэ түвшинд хүртэл саармагжуулах, нөхөн сэргээх шаардлагыг тавихаар гэрээнд заасан байгаа.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 2 номер хариулъя.

**Д.Далайжаргал:** Би нэмээд товчхон, Байгаль орчны байнгын хороо учраас чухал юм хэлчихье. Ер нь төсөл эхлэхэд туршилтын үйлдвэр эхлэхээс өмнө, дараа нь гэж 2 удаа бид нар Шинжлэх ухааны академи Ерөнхий сайдын захирамжаар Мон-Атом зохион байгуулаад 2 том судалгаа хийсэн байгаа. Туршилтыг бол эхлэхээс өмнө болон хойд талд нь хийгээд, бүх судалгаа гарсан. Ер нь тэр уурхайг тойроод 10км-ийн радиуст хоёрхон айл байдаг юм. Ариунболд, Батсуурийнх гэж 2 айл байгаа. 2км-т Ариунболдынх, 7 км-т Батсуурийнх. Мянгат төлийн эзэн ийм айл байдаг. 10км-ийн радиуст 18 худаг байгаа. Бүх худгууд нь бид нарт мониторинг хийгдээд тэнд ус нь ямар байдаг юм гэдэг хяналт шинжилгээ хийгээд явсан. Тэрийгээ Засгийн газрын хуралдааны хуралдаанд дээр бид нар 3 удаа танилцуулаад, тэгээд тэр дээр үндэслэж хөрөнгө оруулалтын гэрээ байж байгаа.

Хүхрийн хүчлийн үйлдвэрийн маш чухал асуудал. Хүхрийн хүчлийн үйлдвэр бол нийт хөрөнгө оруулалтын бараг 20-25 хувийг нь эзэлж байгаа. Хамгийн их зардал, хамгийн их юу орно. Тийм учраас бид нар энэ элементийн хүхэрт Дархан Эрдэнэтээс зарж байгаа элементийн хүхэрт хүрч тулгуурлаад хүхрийн хүчлийн үйлдвэр байгуулна гэдэг зүйлийг ер нь ТЭЗҮ-дээ тусгаад хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалт талтайгаа яриад явж байгаа.

**Б.Бейсен:** Батжаргал гишүүн тодруулъя.

**Ж.Батжаргал:** Тийм ээ. Бид хэд энэ нөхөн сэргээлт, хаалттай холбоотой зардлыг бөөн мөнгө бөөгнүүлж авах тухай, жил жилд хуваах тухай марзан юм яриад болохгүй байгаа юм. Тэгэхээр наад уулын ажлын төлөвлөгөө гэдэг юм уу энэ юмтайгаа уялдаад тэр 3 нэгж талбар дээр ямар дарааллаар явж, ашиглалтын үйл ажиллагаа явснаас хойш ямар хугацаанд эхний хаалтууд гэдэг юм уу юмнууд явах юм бэ гэдэгтэйгээ уялдаж, тэр зардлын хуваарилалт өөрөө тэгш биш оногдож байж. Сая ажлын чанар гүйцэтгэл зөв явах ёстой байхгүй юу. Тэгээд үүнийг гэрээнд та хэд яаж баталгаажуулав гэдэг нэг ийм зүйл.

2 дахь зүйл. Хэдий хэмжээний аюултай хог хаягдал үлдэх юм бэ. Ер нь энэ төслийн үр дүнгээс. Үгүй ээ, тэрийг тэгээд хэдүүлээ ямархуу орчинд яаж хадгалж булшлах юм бэ. Устгачихна гэж би ойлгохгүй л байна л даа. Саармагжуулаад устгачихдаг бол энэ цөмийн хаягдлын тухай хүмүүс их яриад .../минут дуусав/

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 5 номер уу.

**Л.Жаргалсайхан:** Төслийн хүрээнд 3 төрлийн хог хаягдал нь гэхээр энгийн хог хаягдал, дээрээс нь аюултай хог хаягдал, тэгээд бага цацраг идэвхт хог хаягдал гээд ийм 3 төрлийн хог хаягдал гарч байгаа. Аюултай хог хаягдлын хувьд бол ер нь бол яг ашигласан тос, бохир даавуу, цахим цахилгаан хог хаягдал энэ тэр гээд нөгөө энгийн үйл ажиллагаанаас гардаг цацрагийн ямар нэгэн материалтай контактлаагүй хог хаягдлууд орж байгаа. Энэ нь бол 255 тонн гэж

байгаа. Тэгэхээр энэ гэрээнд юу гэж тусгасан бэ гэхээр аюултай хог хаягдлыг бол юу яана. Хэрвээ манай Монгол Улсад тухайн төрлийн аюултай хог хаягдлыг дахин боловсруулдаг ийм үйлдвэр байх юм бол тэр үйлдвэрт нийлүүлнэ. Хэрвээ байхгүй бол энэ компани өөрөө л уурхайн талбай дээрээ нөгөө дахин боловсруулах, устгах ч гэдэг юм уу энэ менежментээ авч явна гэсэн ийм заалт орсон байгаа.

**Б.Бейсен:** 2 номерын микрофон гүйцээж хариулъя.

**Э.Нямдаваа:** Цөмийн нарийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Нямдаваа. Цацраг идэвхт хаягдлын хувьд бол 250 тонн ийм хаягдал гарна гэсэн байгаа. Тэгээд энэхүү хаягдлыг бол төсөл хэрэгжүүлэгч компани төслийн талбай дээрээ ангилж, ялгаад боловсруулаад овор хэмжээг нь багасгаад аюулгүй булшлах ийм заалт орсон байгаа. Ингэхдээ бол мэдээж олон улсын атомын энергийн агентлагийн дүрэм журам болон Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журмын дагуу аюулгүй булшлах ийм зохицуулалт тусгагдсан байгаа.

**Б.Бейсен:** Дэгээр байхгүй. Ундраа гишүүн асуулт асууя.

**А.Ундраа:** Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр бид ингээд Улсын Их Хурлын Байнгын хороодоор бас чуулганы нэгдсэн хуралдаанаар энэ төслийн өөрийнх нь ашиглалттай холбоотой хөрөнгө оруулалтын гэрээ, гэрээний нарийн заалтуудыг хэрхэн хэлэлцээр хийх вэ гэсэн зарчмыг ч баталлаа. Өнөөдөр ингээд детальчилсан асуултууд асууж байна. Энэ бол тал бүрээс нь ярьж байгаа учраас сайн хэрэг. Гэхдээ энэ бол НҮБ-ын одоо Аюулгүйн Зөвлөлийн гишүүн оронтой байгуулж байгаа энэ чухал хэлэлцээрийг бол зүгээр нэг төсөл, нэг уурхайн асуудал гэж үзэхгүй байх нь оновчтой гэж бол би бодож байгаа юм. Тэгээд энэ бол стратегийн ач холбогдол нь бол тэр төслөөсөө хальчихсан эд. Тэгээд сая гишүүд бас анагаах ухаан, бусад салбарын хэрэглээг нь бас асууж байна л даа. Тэгэхээр надад 2 асуулт байна.

Европын холбооны хувьд бол Франц улсын Европын Холбооны гишүүн орон ойлгомжтой. Тэгээд бас цөмийн эрчим хүчийг бол ногоон эрчим хүчний ангилалд хэдэн жилийн өмнө хуульчилж оруулсан. Тэгээд өнөөдөр бид нар Байгаль орчны байнгын хороогоор хэлэлцэж байгаагийнх ногоон эрчим хүчний эх үүсвэр гэдэг талаас нь цөмийн эрчим хүчийг харж, нөгөө талдаа энэ төслийн ач холбогдлыг хэлэлцэхдээ тэр алсын манай Монгол Улсын хөгжлийн бусад бичиг баримтуудад тусгагдсан цэвэр эрчим хүчний эх үүсвэр ашиглахтай холбоотой хүний нөөц бэлтгэх, олон улсын гэрээ конвенцод илүү үүрэг рольтой оролцох, бас Монгол улсыг хөгжүүлэх арга хэрэгсэл гэж харах нь зүйтэй юм уу гэж бодоод байгаа юм. Тэгэхээр Тэгшбаяр доктор юм уу, Манлайжав даргаас асуумаар байгаа асуулт нь бид нар энэ хэлэлцээрийн хүрээнд ялангуяа Франц Улсын Засгийн газартай манай Монгол Улс Засгийн газрын хэлэлцээр байгуулчихсан байгаа. Энэ бол нөгөө олон улсын гэрээний түвшинд хэрэгжиж байгаа шүү дээ. Микро, бага, дунд оврын реакторын судалгаа, фюжер реакторын судалгаа хийх олон улсын институт Монголд байгуулбал зохимжтой юм уу гэж би боддог юм. Тэгэхээр та бүхний байр суурь энэ дээр ямар байна вэ. Бид Цөмийн энергийн газар байгуулбал энэ дээр ийм судалгааны ажил хийж эхлэх бололцоо байгаа юу, үгүй юу гэдгийг асуумаар байна.

2 дугаар асуулт бол Баярхүү элчин сайдаас асуумаар байна. Энэ болохоор 1957 онд олон улсын атомын агентлагаар байгуулагдсан. Өнөөдөр энэ бол НҮБ-ын бүтцийн байгууллага. Тэгээд 2500 гаруй өндөр мэргэжлийн докторын зэрэгтэй болон хуульчид ажилладаг ийм Олон улсын байгууллага байгаа. Тэгэхээр 500 орчим том реакторыг материалын тийм ээ, цөмийн зэвсэглэлд ашиглагдахгүй байхыг баталгаажуулдаг байгаль орчны хяналт хийдэг ийм байгууллага байгуулагдаад ингээд 70 орчим жилийн нүүр үзэж байна. Тэгээд дэлхий нийтийн чиг хандлагыг харах юм бол цаашдаа бага, дунд оврын реакторын тоо нийтдээ 10 гаруй мянган реактор ойрын хугацаанд баригдах төлөвлөгөө байна гэж хэлж байгаа. Тэгэхээр манай Монгол Улс бол цөмийн зэвсэггүй бүсийн статус гэдгээр өөрсдийгөө НҮБ-д хүлээн зөвшөөрүүлж чадсан, энэ талын манлайлагч улс. Тэгэхээр бидний хувьд бол энэ бусад улс орны итгэл найдварыг дааж ингэж ажилладаг. Энэ .../минут дуусав/

**Б.Бейсен:** 1 минут сунгая.

**А.Ундраа:** Баярхүү элчин сайдаас асуух асуулт гэхээр бид нэгэнт цөмийн зэвсэггүй бүсийн статус гээд энэ үе үеийн дипломатуудын хийсэн ажлын ач буянаар ингээд хүлээн зөвшөөрөгдчихсэн байгаа энэ тохиолдолд энэ олон цөмийн реакторууд дээрх материалыг террорист зорилгоор ч юм уу, буруу зорилгоор ашиглахгүй байх safeguard-ийн баталгаа хангах тул манайх бол бас нэг олон улсад итгэл даахуйц орны нэг гэж үзэгдэх бололцоо байгаад байгаа юм. Тэгэхээр бид энэ гэрээ хэлцлийг ашиглаад Монгол Улсынхаа олон улсын тавцан дахь байр суурийг бэхжүүлэх, энэ чиглэлийн олон улсын атомын энергийн агентлаг номер 2 гэх үү ийм байдлаар ажиллах бололцоо байна гэж та харж байна уу. Тийм бол хаанаас нь эхэлж, ямар байдлаар энэ дээр Францын дэмжлэгийг авч болно гэж та харж байна.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 1 номер хариулъя.

**Г.Манлайжав:** Ундраа гишүүний асуултад хариулъя. Цөмийн энергийн комисс Манлайжав. Та бас өчигдөр чуулганы нэгдсэн хуралдаан дээр хэлж байсан. 2010 оны тэр Монгол Францын Засгийн газар хоорондын цөмийн энергийн салбарт хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр. Энд бас тусгагдсан асуудлуудаар бид нар цөмийн эрчим хүч, тэр дундаа таны хэлдгээр 2 жилийн өмнө бол Франц улс Европын Холбоо дотроо цөмийн эрчим хүчийг Грийн таксиномид оруулж Франц бол энийгээ манлайлж явж байгаа. Тэгээд ба бид нар ч гэсэн Коп-26-тай холбоотойгоор бүх улсууд нүүрсхүчлийн хийн ялгарууллаа бууруулах чиглэлд ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар 2024-2028 онд бид нар бол цөмийн эрчим хүчийг нэвтрүүлэх энэ чиглэлд бол нарийвчилсан судалгаа хийх ийм Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд бол албан ёсоор тусгаад энэ жилээс бид нар ажлууд хийгээд явж байна.

Францад бас бид нар энэ чиглэлээр бас хамтын ажиллагаа, судалгаа явагдаж байгаа. Франц улс бол бас Нью Ворд гээд өөрийнх нь семинарыг нэлээд идэвхтэй хөгжүүлж байна. Бид нар бас энийг бас очиж бас үзэж байсан. Монгол Улсад бол үнэхээр бас үнэхээр бас бид нар эрчим хүчний салбартаа, тэр дундаа эрчим хүчний бүтцэд цөмийн эрчим хүчний эзлэх байр суурийг оруулах талаар бол бас судалгаа хийж, цөмийн ЭХЯ-тайгаа бусад судалгаа үйлчилгээний байгууллагууд

их дээд сургуулийн академитай бол хамтран ажиллаж байна. Тэгээд энэ асуудал тодорхой бас болоход энэ Францын тэр тусмаа тэр Си Эй И Ди Эф гээд энэ Францын төрийн өмчтэй байгууллагууд компаниудтай бол хамтын ажиллагаагаа бид нар тогтоосон. Энэ чиглэлд бас нэлээд идэвхтэй ажиллах байх гэж бодож байна. Түрүүний таны тэр хэлдэг safeguard-ийн асуудлаар цөмийн зэвсэг үйлдвэрлэх гэрээтэй холбоотой холбогдуулан баталгаа хэрэглэх асуудлаар Монгол улс олон улсын атомын агентлагтай гэрээтэй ажилладаг. Энэ хүрээнд ч гэсэн өнгөрсөн жил манай энэ Бадрах Энержи компанийн талбай дээр бий болсон 10,4 тонн урантай экуалент нөгөө Хамоним деронатыг гаргаж авсантай холбоотой олон улсын safeguard-ийн 2 эксперт ирж ажилласан. Монгол Улсад. Тэгэхээр бид нар бол энэ чиглэлээр ОУБ-д баталгаагаа хангах чиглэлийн үйл ажиллагаагаа эхлүүлсэн, данстай болсон. Мэдээллүүдээ өгч байгаа гэж бодож байна. Баярлалаа.

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн асуулт асууя. 3 номер хариулъя. гүйцээж хариулъя.

**Н.Тэгшбаяр:** Ундраа гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Таны удаа дараа Улсын Их Хурлын чуулган дээр хэлж байгаа тэр агентлаг байгуулахтай бол санал нэг байгаа. Манайхаас бусад орон бол хэзээ ч 1 жил боловсролын салбарын хатавчинд, нөгөө жил уул уурхайд хатавчинд, дараа жил нь аж үйлдвэрийн салбарын хатавчинд аваачиж байдаггүй л дээ. Бусад орнууд бол ихэнх нь Ерөнхий сайдынхаа дор ийм бодлогыг авч хэрэгжүүлж, өндөр технологийн салбараа авч явдаг. Цөмийн энергиэ ашиглах тал дээр бол яах вэ, өнгөрсөн 60-аад жилийн хугацаанд тасралтгүй судалгаа хийж явсан боловч одоо энэ Цөмийн энергийн агентлаг байгуулагдсаны дараа бол энийг бол эрчимжүүлж Засгийн газрын мөрийн хөтөлбөрт заагдсан 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт заагдсан тэр цөмийн эрчим хүчийг ашиглах тэр нарийвчилсан судалгааг бол яаралтай хийх шаардлагатай.

Монгол Улсын нөхцөлд таарсан атомын станцыг байгуулах дээр бол энэ судалгаа маш том суурь судалгаа болж өгнө. Одоо атомын станцыг бол дотроо жижиг, бичил, дунд бол 300 хүртэл мегаватт бол бичил, 300-7 бол дунд, 700-с дээшээ бол том оврын атомын станц гэж байгаа. Монголд бол тэр бичил 300 хүртэлх бичил болон бага оврын атомын станцыг барих нь илүү тохиромжтой гэж би бол мэргэжлийн хүний хувьд бол үздэг. Энэ тал дээр яах вэ, олон жил энэ чиглэлээр ажиллаж байгаа хүний хувьд Францууд, Солонгосчууд, Америкууд бол Монголд энэ чиглэлийн атомын станцыг барихад бол жишээлбэл нийт хөрөнгө оруулалтынх нь 85 орчим хувийг нь бол тухайн улсаас санхүүжүүлээд, үлдсэн нь бол Монгол Улсын оролцоо байдлаар хийгээд ингээд цэвэр эрчим хүчийг ашиглах бүрэн боломжтой гэдэг дээр мэргэжилтнүүд байнга хэлдэг.

Тэгэхээр таны энэ хэлж байгаа ажлуудыг бол яаралтай ажил хэрэг болгож эрчимжүүлэх шаардлагатай гэдэгтэй санал нэг байна. Баярлалаа.

**Б.Бейсен:** 5 номер хариулъя.

**Д.Баярхүү:** Манай Ундраа гишүүний бас түрүүн тавьж байгаа асуудал бол их чухал асуудал. Тэгэхдээ өнөөдөр энэ хэлэлцэж байгаа хууль болоод одоогийн Их Хуралд оруулах гэж байгаа асуудалтай бол шууд холбогдохгүй. Энэ чинь 2028 онд үр дүн нь гараад, анхныхаа хамтарсан үйлдвэрийн бүтээгдэхүүнийг олон улсын

зах зээлд гаргаад, үйлдвэр бүрэн хэмжээгээр ажиллаад ирнэ. Тэгээд тэр чинь газар доор уусган баяжуулах аргаар олборлож байгаа уран. Тэгэхээр бол олон улсын энэ терроризм, олон улсын тэр халдлага, ямар нэгэн хорлон сүйтгэх тийм ажиллагаанаас бол арай ангид хол юм. Тэгээд манай улс чинь өөрөө газар зүйн байршлыг нь аваад үзэх юм бол цөмийн зэвсэгтэй 2 том гүрнээр хүрээлэгдчихсэн. Цөмийн зэвсгийн тэр ямар нэгэн атомын болоод цөмийн террорист халдлага үйлдэх магадлал багатай 2 улстайгаа иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай маш найрсаг итгэлцсэн харилцаатай, цэргийн батлан хамгаалахын салбарын хамтын ажиллагаа хөгжчихсэн ийм улсад бол тэр аюул заналын тухай асуудал бол арай холуур байх. Энэ манай цэргийн номлол ба үндсэн аюулгүй байдлын үзэл баримтлал гээд бүгдэд нь тодорхой заачихсан байгаа.

Олон улсын тавцанд бид яах вэ гэх дээр зэрэг энэ яах вэ, манай ажлын группийн санал биш шүү. Би нөгөө олон улсын харилцааны мэргэжилтний хувьд ярихад бол Нидерландын Хак хотод олон улсын химийн зэвсэг хориглох байгууллага байгаа. НҮБ-аас байгуулсан. Тэнд тухайн цагтаа Монголын 3-4 ч хүн ажиллаж байсан. Манай химийн цэргийн мэргэжилтнүүд 3 хүн, гадаад яамны дипломат 1 хүн. Тэгээд байгууллагаараа Нобелийн энх тайвны шагнал авсан шүү дээ. Одоо ингээд байцгааж байгаа шүү дээ хүмүүс нь. Түүнтэй адилхан энэ байгууллагад бол дахиад манайх өөрийнхөө мэргэжилтнүүдийг олныг оруулж ажиллуулах шаардлагатай юм байна лээ. Тэгж байж манай энэ цөмийн болоод атомын эрчим хүчний асуудалд чинь бол нөгөө хаягдал булшлах барих, тэр цацраг идэвх хор энэ тэр гээд ярих юм бол энэ байгууллагын шууд хариуцах ажил болоод явчхаж байгаа юм. Тэгээд нөгөө олон улсын атомын эрчим хүчний агентлаг Магата байна. Тийм ээ. Вена-д байдаг. Энд ч гэсэн манайх өөрийнхөө тэр олон талт дипломатын мэргэжлийн хүмүүсийг бол маш олноор нь оруулах шаардлагатай болчихсон. Ер нь олон талын мэргэжилтнүүдийг манайх маш олноор нь энэ 2 байгууллага руу оруулж ажиллуулсан тохиолдолд бол манай өөрийн аюулгүй байдал, манай энэ менежментийн асуудал чинь сайжраад явчихна гэж би боддог юм.

**Б.Бейсен:** Ундраа гишүүн тодруулъя.

**А.Ундраа:** Баярхүү элчин сайд баярлалаа. Тэгэхдээ та миний асуултыг ер нь буруу ойлгочихлоо. Би бол манайд ямар нэгэн аюул занал учирч байгаа юу гэдэг талаас нь ерөөсөө асуугаагүй. Манайд ямар нэгэн террорист халдлага хийгдэх гэж байгаа юм биш үү гэдэг талаас ерөөсөө асуугаагүй. Би бол ер нь цэвэр нэгэнт Францтай бид нар Засгийн газар хоорондын хэлэлцээртэй, алсын бодлоготой ямар байдлаар ажиллах бололцоо байна уу. Манай Монгол Улсын хувьд бол олон улсын тавцанд эзлэх байр сууриа бэхжүүлж байх нь л бид нарын батлан хамгаалахын ч тэр, гадаад бодлогын ч тэр чухал нэг үзүүлэлт. Тэр үүднээсээ тэгээд цөмийн зэвсэггүй бүсийн статусаа батлуулахад 30 гаруй жилийн хөдөлмөр орсон. Тэгээд нэгэнт энэ салбарын тоглогч болох гэж байгаа бол алсдаа арай жоохон амбицтай байх нь зөв гэдэг санааг л хэлж байгаа юм. Тэрнээс биш бид нар цөмийн цахилгаан станц барилаа барилаа гээд саяын Тэгшбаяр докторын хэлж байгаа шиг их л сайндаа маш цөөхөн 1, 2-ыг л баривал барих биз. Тэгэхдээ бид нарын манай өөрийн дотоодын хэрэгцээ, манай өөрийн дотоодын асуудал дээрээ ингэж явцуу сэтгээд л байвал би .../минут дуусав/

**Б.Бейсен:** Учрал сайд гүйцээж хариулъя.

**Н.Учрал:** Ундраа гишүүн их чухал асуудлыг бас өчигдрөөс хойш хөндөж байгаа. Тэгээд үнэхээр энэ Францын Орано компанитай хийж байгаа хөрөнгө оруулалтын гэрээ бол зөвхөн санхүүгийн үр өгөөж талаасаа биш, энэ бол геополитикийн асар өндөр ач холбогдолтой л гэж би дүгнэж байгаа юм. Яг хөрөнгө оруулалтаа ярих юм бол Оюутолгойтой харьцуулшгүй. Жижиг төсөл. Гэхдээ үүний цаана дэлхий нийт бид нарыг бас анхааралтай ажиглаж байна. Монгол Улсад цаашдаа хөрөнгө оруулалт орж ирэх юм уу, үгүй юм уу гэдэг ийм асуултын тэмдэг үүний ард байгаа. Эсвэл камерын өмнө гарахаараа бид нар чинь бүгдээрээ хэн нь илүү эх орондоо хайртай вэ гэдэг шиг ийм хамаа замбараагүй юм ярьдаг. Тэгээд дэлхий нийт энийг анхааралтай харж байгаа. Анхааралтай харж байгаа шүү дээ.

Тийм учраас Франц, Монгол 2 орон бол цаашдаа стратегийн түншлэлийн түвшинд харилцаатай улс болох ёстой. Үүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч .../минут дуусав/

**Б.Бейсен:** Учрал сайдад нэг минут сунгая.

**Н.Учрал:** Ерөнхийлөгчийн Франц улсад хийсэн айлчлалын үеэр 2 Ерөнхийлөгчийн хооронд яригдсан ийм яриа. Стратегийн түнштэй болоход хэд хэдэн салбарт хамтран ажиллая гэж.

Нэгд энэ ураны хөрөнгө оруулалтын гэрээг явуулъя. Онцгой байдлын салбарт ажиллая. Тэр хавдрын эмнэлгийн асуудал бас яригдсан. Дээрээс нь үндэсний хиймэл дагуул. Тэгээд их мэдэгч нараас болоод нөгөө бүгдээрээ сансар судлаач, бүгдээрээ уран мэддэг, бүгдээрээ физикч болсноос болоод ингээд эхнээсээ унаж эхэлж байгаа юм. Тэгэхдээ энэ бол цаашдаа НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 5 орны нэг улстай хөрөнгө оруулалтын гэрээ хийснээрээ хөрөнгө оруулалтын орчин сайжирна.

2-т энэ чинь зөвхөн Францтай холбоотой асуудал биш ээ. Энд бид бүтээгдэхүүн үйлдвэрлэснээрээ тэр Европын холбооны 8 оронд тэр бүтээгдэхүүн нийлүүлэх гээд байна шүү дээ. Тийм учраас ийм стратегийн ач холбогдол гэдэг талаас нь харна гэж энэ дунд .../минут дуусав/

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн асуулт асууя.

**Г.Ганбаатар:** Учрал сайдад тэр Их Хурлын гишүүдийг их их мэдэгч эд нар гэж ярьж болохгүй байх. Та бас энэ үгээ бодож хэлэх хэрэгтэй.

Миний асуулт 4 чиглэлээр байгаль орчны, хог хаягдлын чиглэлээр, хүхрийн үхжилттэй холбоотой, устай холбоотой, эрчим хүчтэй холбоотой. Түрүүн би нөгөө Төсвийн байнгын хороо дээр 1 асуултаа хариулт бүрэн авч чадаагүй учраас тэр устай холбоотой асуулт дээр бас нэмж тодруулга авчихъя.

Хог хаягдал дээр сая тэр булшлах тухай юм ярьчихлаа. Би өнгөрсөн жилийн тэр Орано группийн ерөнхийлөгч Николай Майстэй хийсэн ярилцлагыг уншиж байсан. Цөмийнхөө хог хаягдлын цацрагт идэвхт бодисоо булшлахгүй л гэсэн байсан. Манай улсын хууль бас тийм байдаг байх. Монгол Улсад цөмийн хаягдал булшлахгүй гэсэн тийм байдаг шиг санаж байна. Тэрийгээ тодруулж өгнө үү.

2 дахь нь хүхрийн хүчилтэй холбоотой. Манай нөгөө Ганбаатар гишүүн бол өдөрт 15 вагон хүхрийн хүчил газарт булна гэж яриад байгаа шүү дээ. Та нөхдүүдийн оруулж ирж байгаа танилцуулга дээр хүхрийн хүчлийн эхний 3 жилд төсөл хэрэгжсэнээс хойш 3 жилийн дотор байгуулна. Хоногт 700 тонн гэж байгаа байхгүй юу. Ингээд нөгөө шингэн ачааны шилжүүлээд үзэхээр 15 вагон гэдэг бараг дүйгээд байгаа байхгүй юу. 700 тонн гэдэг чинь хоногт хэрэглэх хэрэглээ юм уу. Түүнтэйгээ уялдуулж ТЭЗҮ нь хүхрийн хүчлийн шинэ ТЭЗҮ тэгж гарсан юм уу.

3 дахь асуулт нь Орано хуучин Арева байсан. Энэ чинь том эрчим хүчний цөмийн энергийн болоод энэ юуныхаа салбарт бол их том тоглогч л доо. Манайх бол эрчим хүчний дутагдалтай улс. Түрүүн Төсвийн байнгын хороон дээр манай улсын нийт хэрэглээ 584,3 гэх шиг боллоо. Тэгээд нөгөө 10 хувиа авах юм бол 2500-с 250. Энэ гэрээ хэлцэл дотор ер нь цаашдаа ногоон эрчим хүч болоод цөмийн энергийн эрчим хүчний чиглэлээр ямарваа нэгэн яриа байгаа юу. Айхтар нууц биш бол. Эрчим хүчнийхээ хомсдолыг болоод, ногоон эрчим хүчний чиглэлээр яриа байгаа юу.

3 дахь асуудал нь түрүүн Батбаяр дарга хэлэхдээ гэрээнд усны нөөцийн жигд хуваарилалт, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх тухай анхаарч байгаа гэж ярьж байсан. Энэ чинь миний асуултад нөгөө говийн бүс Хэрлэн-Тоонот, говийн бүсийг усжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг усаар хангах чиглэлээр яг энд бас яриа хэлцэл байна уу. Миний гол сонирхоод байгаа зүйл тэр байхгүй юу. Эцэст нь зүгээр хэлэхэд би яг энэ орон нутагт чинь 8 жил бүр багийн дарга, сум, аймгийн удирдлага хийгээд, зовлонг нь мэдэх хүний хувьд хэлэхэд тэр уусган баяжуулах олборлолт гэдэг чинь өөрөө хар сэв дагуулаад, болгоомжлол дагуулаад байдаг байхгүй юу. Би бол үргэлж дэмжиж явсан. 10 жилийн өмнө энд бас ад үзэгдээд явж байсан хүн байхгүй юу. Шинжлэх ухааны үндэслэлтэй, хүнд энгийн хүрэх юмнуудыг сайн хийж байгаарай гэж.

Манайхан ингээд зөв юмны төлөө ад үзэгдэх эр зориг байдаггүй. Яг түрүүн бас Бат-Эрдэнэ сайд хэлсэн байхгүй юу. Тэгшбаяр докторыг өөр хэн дуугарч байна. Дуугарах хэрэгтэй шүү дээ .../минут дуусав/

**Б.Бейсен:** Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгээд ер нь ийм стратегийн том төслүүдийг бид нар сэтгүүлч нар ч бай, хэвлэл мэдээлэл ч бай, иргэд ч бай олон нийт дээрээ хамтдаа хэлэлцэж байгаа бас зөв жишиг л дээ.

Гэхдээ яг энэ мэргэжлийн эксперт, судлаач, эрдэмтдийн санал шүүмжийг сонсохгүйгээр бас урагшлахад их хэцүү юм байна лээ. Тийм ч учраас би бол энэ том ажлын хэсгийг ахалсны хувиар энэ олон улсын 3 зөвлөх үйлчилгээ, энэ дотоодын зөвлөхүүд, 5 ажлын хэсэг, дэргэдэх дэд ажлын хэсгүүд гээд мэргэжлийн хүмүүсийн үгийг л сонсож, тэр хөндлөнгийн үнэлгээнүүдэд дүгнээд л ингээд нэгтгээд явж байгаа. Тэрнээс нэг хүн бүх салбарыг мэддэг юм гэж юу байх вэ. Тэгэхээр мэргэжлийн хүмүүсийн дуу, байр сууриудыг сонсоод үнэхээр байгаль орчны ажлын хэсэг яаж ажилласан гэдэг тэр дүгнэлтүүдийг нь өгөөд л, тэр хөрөнгө оруулагч талтай хэлэлцээд, оруулаад ингээд байгаль орчныг тогтворжуулахгүй ч гэдэг юм уу ингээд дүгнэлтэд хүрээд л одоо ингээд эцсийн байдлаар ажлын хэсгүүдээс мэргэжлийн хүмүүс та нар яг энд итгэлтэй байна уу гээд эцсийн байр сууриудыг нь сонсоод, нэгтгээд явсан.

Тэрнээс биш хэн нэгнийг мэргэжлийн хүмүүсийн өмнөөс би дүгнэлт гаргаад эсвэл би өөрийнхөө эмоциор асуудалд хандаж болохгүй. Тийм ч учраас салбарын сайдууд ахалсан. Салбарын сайдууд дэргэдээ мэргэжлийн хүмүүсээр багаа бүрдүүлээд, энэ багийн тусламжтайгаар энэ ажил урагшилж байгаа юм. Тийм учраас би бас асуудалд хандахдаа ингэж хамаагүй юм болгоныг мэддэг царайлж бас болохгүй гэдэг ийм байр суурийг бол байнга илэрхийлж байгаа юм.

Монголд цаашдаа хөрөнгө оруулалтын гэрээ, ер нь хөрөнгө оруулалтын орчин сайжрахад зарим юмаа бас мэдэхгүй юмаа мэдэхгүй гэдгээ хүлээн зөвшөөрч бид сурах ёстой юм байна. Ийм хандлагаа өөрчлөхгүй бол би жишээ нь Баярхүү доктортой олон улсын харилцаа ярина гэдэг утгагүй. Би Тэгшээ доктортой би нэг цөмийн физик ярина гэж утгагүй. Би үнэндээ энэ мэргэжлийн хүмүүсээр л та нарын дүгнэлт зөв бол бид урагшилъя. Энэ дээр олон улсын зөвлөхүүд яаж ажилласан юм. Дотоодын зөвлөхүүд яаж ажилласан юм бэ. Улс төрийн манлайлал хэрэгтэй бол бид хийгээд явах ёстой. Алийн болгон тэгээд л сошиал дээр бас зарим хүмүүс амь орж байна шүү дээ. Амь орно л доо. Тэгэхдээ хэн нэгэн хүн энэ галыг бариад ингээд манлайлал үзүүлээд явах л ёстой. Цаг үе мөн үү гэвэл мөн л юм байна. Тэгэхээр энэ гэрээ бол өөрөө нөгөө уран олборлох гэрээ болохоос биш нөгөө эрчим хүчний бас гэрээ биш. Гэхдээ энэ гэрээ явснаараа цаашдаа бас эрчим хүчний салбарт, тэр нөгөө АЦС-тай болоход судалгаа шинжилгээ эхлэхэд энэ талаасаа дэмжлэг болно. Тэр утгаараа гэрээ дээр Монгол Улс нь ураны зах зээлийн гол тоглогчдын нэг болж, олон улсад нүүрсхүчлийн ялгаруулдаггүй эрчим хүчний эх үүсвэрийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байна л гэдэг байдлаар энэ нөгөө алсын хараагаа суулгаж өгсөн.

Мэдээж бид нар чинь нөгөө Парисын хэлэлцээрт нэгдсэн хүлэмжийн хий ялгаруулах ийм үүрэг хүлээчихсэн орон. Тэр утгаараа бид нар алхам хийж байгаа болохоос биш энэ төсөл явлаа гээд энэ эрчим хүчний яг төсөл гэдэг шууд утгаараа бас биш ээ. Гэхдээ мэдээж энэ Европын холбооны оронтой ингээд харилцаа хамтын ажиллагаа өрнөж байгаа учраас ийм дэвшил гарах талаасаа гэдэг утгаар нь энэ дээр бас томъёолж өгсөн.

Дээрээс нь бас Ганбаатар гишүүн бол орон нутагт ажиллаж байсан хүн. Тэгэхээр үнэхээр энэ орон нутгийн хөгжлийг дэмжих гээд тухайн бүлэг оруулсан нь бас энэ хөрөнгө оруулалтын гэрээний сайн жишиг боллоо. Ер нь бараг энэ чинь 2 тэрбум орон нутаг руу очих ийм бололцоонууд байгаа байхгүй юу. Дээрээс нь тусгай АМНАТ-аар орлуулсан хуримтлалын сан руу явсан ч нөгөө өсөн нэмэгдэх АМНАТ, суурь АМНАТ-ын 65 хувийг нь Ирээдүйн сан руу авчихаар орон нутгийн сан руу очих мөнгө нь өсөн нэмэгдэх АМНАТ тооцож байгаа учраас дахиад нэмэгдчихэж байгаа юм. Дээрээс нь өнгөрсөн хугацаанд тэр тэрбум төгрөгийг 4 жил өгчихсэн, дахиад уурхай ашиглаад эхлэхээр 1 сая доллар олгогдоод ингээд эхлэхээр тэр орон нутгийг дэмжих маш олон шууд өгөөж энэ бол шууд бус дам нөлөөлөл бол маш их шүү дээ. Ажлын байр, тэнд одоо зах зээл өрнөх гээд ингээд олон боломжууд бол орон нутагт бий болно. Тэгээд үүнд аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга хамт .../минут дуусав/

**Б.Бейсен:** 1 номер нэмж хариулъя.

**Г.Манлайжав:** Гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Хог хаягдлын асуудал дээр түрүүн хэлсэн 3 төрлийн хог хаягдал байгаа гээд. Бид нар бол байгалийн урантай холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр бид нар



байгалийн гаралтай цацраг идэвхт материалтай, тэрний аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлуудыг зохицуулдаг хяналттай.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа нэлээд олон дүрмүүд байгаа. Засгийн газар баталсан, цөмийн комиссоос баталсан хүдрийн олборлолттой холбоотой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын менежментийн дүрэм гэж байна. Цацрагтай холбоотой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын менежментийн дүрэм, цацрагт ашигт малтмалыг олборлох боловсруулах үйл ажиллагаатай холбогдон мөрдөх цацраг аюулгүй ажиллагааны дүрэм гээд энэ дээр бид нар хаягдлуудыг яаж устгах талаар тавьсан. Энэ бол олон улсын холбогдох байгууллагуудын дүрэм журмыг барьж хийсэн ийм дүрмүүд. Тэр дээр бага идэвхтэй цацраг идэвхт хаягдлуудыг бол юуны талбай дээр уурхайн талбай дээр нь цомхотгоод түрүүний Нямдаваагийн хэлдгээр ийм булшлах үйл ажиллагаанууд явагдах юм.

Түрүүний таны хэлдэг нөгөө өндөр идэвхтэй цацраг идэвхт хаягдал гэдэг бол энэ 2 бол 2 өөр зүйл. Нэг нь байгалийн гаралтай, нөгөөдөх нь бол технологийн процесс бий болсон. Тэр тусмаа нөгөө реактор дээр шарагдаад бий болсон өндөр идэвхтэй цацраг идэвхт хаягдал бол бид нартай ямар ч хамаарал байхгүй.

Өнгөрсөн оны 11 сард Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулахдаа бид нар яг энэ тодорхой бүр зүйл заалтыг зааж өгсөн. Гаднын Монгол Улсад үүсээгүй цацраг идэвхт хаягдлыг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх, тэр тусмаа булшлахыг бол хориглодог. Бусад хэд хэдэн конвенц дээр ч гэсэн бид нар бол ийм юманд хориотой байгаа. Бид нар бол өөртөө үүссэн цацраг идэвхт хаягдлыг өөртөө менежмент хийх үүргийг хүлээдэг. Манай хөрөнгө оруулалтын гэрээ дээр төсөл хэрэгжүүлэгч компанийн 100 хувь өөр дээрээ үйл ажиллагааг өөрийнхөө зардлаар дүрэм журмын дагуу хийх үүрэг хүлээсэн.

**Б.Бейсен:** 5 номер тодруулж хариулъя.

**Л.Жаргалсайхан:** ТЭЗҮ-д жилд 208 мянган тонн хүхрийн хүчил ашиглана гэж заасан байгаа. Энэ хүхрийн хүчил бол бүгдээрээ газрын доорх уусгалтад ашиглагдахгүй. 3 зорилгоор ашиглагдана.

1 дүгээрт газрын доорх ураныг уусгахад ашиглагдана.

2 дугаарт ураныг уусгаж гар гаргаж ирээд давирхай дээр суулгаад тэгээд буцаагаад салгаж байгаад тэгээд тэр давирхайгаа сэргээхэд бас ашиглагдана.

Дээрээс нь нөгөө хүхрээс хүхрийн хүчил үйлдвэрлэх үйлдвэрээс хий ялгарна. Тэр хийг цэвэрлэхэд бас ашиглагдана. Ингээд 3 зорилгоор ашиглагдана. Ер нь олон улсын туршлагаар ингэдэг юм байна. Нөгөө 5-10 хувь. Нийт ашигласан хүхрийн хүчлийн 5-10 хувь нь газрын доорх усандаа үлддэг. Тэгээд тэрийг нь нөхөн сэргээдэг гэдэг. Тэр бусад хүхрийн хүчил нь хааччихаж байгаа юм бэ гэхээр нөгөө давирхайгаас уранаа салгаад, тэгээд дахиад тэрнээсээ нөгөө амекаар тунадасжуулаад яг нөгөө нэг аммонийдиоранат гээд нөгөө шар нунтгаа гаргаж аваад, тэгэхээр нөгөө хүхрийн хүчлийнх нь сульфат нь уусмалдаа үлддэг. Тэгээд тэр уусмалаа буцаагаад саармагжуулалтад ашиглаж байгаад ураных нь агууламж 5гр литрээс бага болоод ирэхээр нөгөө хаягдал ус хадгалах сан руу хийгээд, тэгээд тэрд ууршаад, тунадасжаад амоним сульфат гээд ийм хэлбэрээр

тунадасжаад үлддэг. Тэгэхээр бас бүх хүхрийн хүчил бүгдээрээ газрын доорх усанд үлдэнэ гэж ойлголт бол байхгүй.

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн тодруулъя.

**Г.Ганбаатар:** Энэ мэдээлэл дээр чинь байна л даа. Сая та болохоор жилдээ 208 тонн гээд хүхрийн хүчил. Мянган тонн. Энэ өдөртөө 700 тонн юм уу. Баярлалаа.

**Б.Бейсен:** Идэрбат гишүүний асуулт асууя.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Монгол Улс байгалийн баялгаа эргэлтэд оруулах олон чухал алхмуудыг л хийж байна. Үнэхээр энэ гэрээ гээд одоо байгуулах энэ гэрээг бол ингэж олон талаас нь ярьж хэлж байгаа нь бол зөв. Бид гэрээгээ хагас дутуу хийснээс болоод бүхэл бүтэн Оюутолгойн ордын гэрээгээ цэгцэлж чадахгүй. Гэрээгээ хайнга хийснээс тухайн үеийн нөхцөл байдалдаа тохируулж бас хайнга хандсанаас болоод Петро Дачин Тамсгийн гэрээг өнөөдөр хүртэл өөрчилж чадахгүй олон боломжуудаа алдаж байгаа. Энэ гашуун сургамж дээр харин энэ ураны гэрээг бол бас нэлээн Монгол Улсын хууль тогтоомж, олон зүйлүүдийг бас харсан сайн гэрээ болж байна гэж дүгнэж байгаа юм.

Тэгээд өнгөрсөн жил батлагдсан Баялгийн сангийн хуулийн тэр хэрэгжилтийг ч гэсэн хангалттай сайн бас гаргаж өгч байна гэж. Тэгэхээр эцсийн дүндээ ер нь энэ ураныг ашиглаж Монголд ямар ашиг олох гээд байгаа вэ гэдэг дээр иргэд эцсийн асуулт нь тэр л байгаа шүү дээ. Тэгэхээр энэ төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын төсөвт хэдий хэмжээний доллар, хөрөнгө орж ирнэ гэж ингэж тооцож байгаа вэ. Энийг зүгээр энгийн үгээр тайлбарлаад өгөөч гэж 1 дүгээрт энэ.

2 дугаарт та бүхэн бол энэ Казахстаны жишээг бас их ярьж байгаа. Манайхан ч бүүр очиж үзсэн. Үнэхээр ч энэ ураны салбар дээр бол Казахстан маш мундаг явж байгаа юм байна. Тодорхой хугацааны өмнө бол бид, Казахстан 2 яг л адилхан л байсан юм байна лээ л дээ. Өнөөдөр бол Казахстан тасраад явчихсан юм байна лээ. Казахстан уранаа олборлоод ухаад, гэхдээ 2024 оны 10 сард шиг санаж байна. Бүх ард түмнээрээ тэр атомын станц хийх зөвшөөрлөө санал хураалтаар шийдчих шиг болсон. Би тэгж ойлгосон. Тэгэхээр ингээд уранаа олборлож эхэлсэн шигээ энэ атомын эрчим хүч рүү орох том алхмыг энэ улс гүрэн хийж байна. Тэгэхээр би яах вэ, энэ өмнөх Ундраа гишүүний асуулт олон асуултууд дээр үүний хариу ерөнхийдөө гарчихлаа. Ер нь гэхдээ энэ олборлолт, энэ бүхний цаана бол энэ атомын эрчим хүчний суурийг тавих том Монгол төрийн бодлого бас явж байгаа юм байна. Эхлэлийг нь тавьж байгаа гэж ингэж бас бодож байгаа нь зөв үү гэж 2 дахь асуулт байна.

3 дахь нь. Энэ чинь хугацаа их богино болчихлоо. Би дараа нь тодруулъя.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Үндэсний баялгийн сангийн хуулийн эцсийн хэлэлцүүлгийг чуулганаар хийх гэж байна. Энэ хууль батлагдвал төрийн эзэмшлийн 34 хувийг тусгай АМНАТ дор орлуулсан бол тэр хэсэг нь хуримтлалын сан руу буюу иргэдийн данс руу очих бололцоотой болно. Харин Суурь АМНАТ бол угаасаа тэр 65 хувийг нь Ирээдүйн сан руу аваад, үлдсэн нь бол Орон нутгийн сан,

Тогтворжуулалтын сан руу хуваарилагддаг. Одоо энэ төслийн хүрээнд өсөн нэмэгдэх АМНАТ буюу яг өнөөдрийн үнээр бол 6 хувь гээд тооцоод, цаашдаа бол ингээд өсөн нэмэгдэнэ гэж үзэхээр тэр хэсэг нь бол дахиад Ирээдүйн өв сан руу 65 хувь нь хураагдаад, үйлдсэн орон нутаг руу явахаар орон нутгийн сан дээр бол дэмжлэг нэмэгдэнэ.

Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын гэрээг байгуулснаар улс орон нутгийн төсөвт жилд 520 тэрбум, төслийн нийт хугацаанд бол 17,1 их наяд. Баялгийн санд бол 61,5 тэрбум, төслийн нийт хугацаанд 2 их наяд баялгийн санд төвлөрнө гэж үзэж байгаа. Энэ бол шууд өгөөж. Зүгээр 1600 орчим ажлын байр нэмэгдэх, түүний 90 хувь нь Монгол хүмүүс ажиллах, ингээд цалин хөлсийг 7-оос дээш сая төгрөгөөр тооцох ч гэдэг юм уу ингээд хэлэлцээний явцад яригдсан асуудалд нөгөө дам өгөөж маш өндөр л дөө. Шууд бус үр өгөөжүүд их өндөр байх нь бол дамжиггүй.

Зүгээр бид нар нөгөө Баялгийн сан нь иргэдийн хуримтлалын дансыг нэмэгдүүлэе гээд, эхлэл хийгээд сая нөгөө 5 уул уурхайн компани хуримтлалын санд орлого төвлөрүүлээд эхэлсэн. Ингээд 2028 онд уул уурхай ашиглалтын үе эхлэхээр АМНАТ-ын орлого бол ороод ирнэ. Ноогдол ашиг бол 2031 оноос хойш яригдах гэж байна. Тэгэхдээ бид нар чинь энэ удаа нөгөө ноогдол ашгийн эрсдэлээс ангижирч, шууд нөгөө борлуулалтаас нь АМНАТ авах гэж байгаа учраас тэр тусгай АМНАТ-аас орж ирэх 5 хувь бол 2028 оноос уурхай ашиглаад эхлэхээр иргэдийн хуримтлалын данс дээр харагдаад эхлэхээр итгэл үнэмшил төрнө л дөө. Зүгээр бусад суурь АМНАТ, өсөн нэмэгдэх АМНАТ бол бас л 2028 оноос уурхай ашиглаж эхлэх үеэс явагдана. Тэгээд ер нь бол төсөл, гэрээ байгуулагдах бол нэг асуудал. Гэрээ хэрэгжүүлнэ гэж их том зовлон байгаа. Бас ер нь бол тийм учраас цаашдаа бол уул уурхай яам, гишүүд бас хэлээд байгаа. Энэ Цөмийн энергийн агентлагийг шинээр байгуулж, энэ чинь төсөл хэрэгжүүлэх нь байна шүү дээ. Шинээр байгуулаад ингээд хариуцлагатай болгох, араас нь бид нар бол Их Хурал дээр ч гэсэн шахаж шаардах төслийн хугацааг нөгөө уурхай ашиглах хугацааг хойшлуулахгүйн тулд шаардлагатай дэмжлэгүүдийг үзүүлээд, ингээд араас нь мэдээллүүдийг сонсоод шахаж шаардахгүй бол нөгөө гэрээ байгуулагддаг, яг төсөл хэрэгжих ажил чинь бол нэлээд асуудал дагуулна. Тийм учраас төсөл хэрэгжилт дээрээ сайн хяналт тавьж байж бид нарын өнөөдрийн яг төлөвлөсний дагуу энэ төсөөлж байгаа санхүүгийн үзүүлэлтүүд биеллээ олно гэж ингэж үзэж байгаа.

**Б.Бейсен:** 1 номер гүйцээж хариулъя.

**Г.Манлайжав:** Идэрбат гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Манлайжав. Цөмийн энергийн комисс. Монгол Улсын Алсын хараа 2050. Ер нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал дээр бас ер нь бид нар эрчим хүчний аюулгүй байдлаа хангах, тэр тусмаа энэ ногоон эрчим хүчийг нэвтрүүлэх чиглэлээр бодлого байгаа. Монгол улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого бол хүчин төгөлдөр үйлчилж байна. Энд ч гэсэн бид нар цөмийн эрчим хүчийг бол нэвтрүүлэх бодлого төлөвлөгөөтэй явагдаж байгаа. Таны бас бодож байгаатай бол би санал нэг байна. Бид нар ирээдүйд энэ цөмийн эрчим хүчийг нэвтрүүлэх асуудал дээр бас энэ уран олборлож байгаа улсуудын хувьд манай хөрөнгө оруулалтын гэрээ дээр бас та бүхэн гишүүд өмнөх Байнгын хороодоос асуудал яригдаж байсан. Гарсан

бүтээгдэхүүний 10 хүртэлх хувийг Монгол Улс яг ижил нөхцөлөөр бол өөрсдөө худалдаж авах эрх нээгдэх ийм заалт бол байгаа.

Тэгэхээр түрүүн хэллээ. Жилд 2500 тонн шар нунтаг үйлдвэрлэж байгаа энэ үедээ 10 хувийг бид нар жишээлбэл 250 тонныг өөрөө худалдаж авах эрх үүснэ. Ер нь бол дэлхийд Монгол Улсыг бол 300-аад мегаваттын эрчим хүчний хэрэгцээг бол цөмийн эрчим хүчээр хангавал болох юм байна гэсэн 2050 он гэхэд манай эрчим хүчний нийт хэрэгцээ бол 3 гегаватт руу дөхнө. Тэрний 10 хувь гэж үзэх юм бол 300мвт-ын асуудлыг бас ЭХЯ-тай бас ярьж байгаа. 300мвт-ын станц ажилласан тохиолдолд бол бид нар 60-70 тонн шар нунтгийг бол түлш болгоход болох юм байна лээ. Тэгэхээр жилийн хэрэгцээ шүү дээ. Тэгэхээр 60-70 тонн шар нунтгаа бас цөмийн түлш болгоход бараг ойролцоогоор 2 дахин илүү 50 хувийн зардал гардаг юм. Түүхий эдээсээ бол түлш олгох зардал. Тэгээд бид нар бол ойролцоо 120-160 тонн шар нунтагтай байхад бол цөмийн эрчим хүчний станцтай болсон тохиолдолд Монгол Улс 300мвт-ын станцын түлшээ бид нар өөрсдөө, нэг ёсондоо гаргаад хүнээр бол хийлгэгч ийм бололцоо бүрдэх юм байна гэсэн ийм тооцоолол байгаа. Баярлалаа.

**Б.Бейсен:** Идэрбат гишүүн тодруулъя.

**Ц.Идэрбат:** Баялгийн сангийн хууль сая яригдлаа. Үнэхээр Монголчууд байгалийн баялагтаа эзэн болох энэ их баян улсын иргэн яаж хувь хүртэх вэ гэдэг асуудал тэр 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлт 2024 оны баялгийн сангийн хуулиар бол тодорхой болсон. Тэгэхээр би нөгөө баялагтаа эзэн болгоход бас дараа дараагийн энэ том ордуудыг иргэд хувь хүртдэг байх тэр бололцооны талаар бас энэ удаа асуух гээд байгаа юм. Хэрэг эрхлэхийнхэн байна, яамныхан байна, Эрдэнэс Монголынхон байна.

Тэгэхээр 2007 онд Улсын Их Хурлын даргын захирамж гараад стратегийн 15 орд гээд энийг хүн болгон мэддэг болсон. 2 дахь хавсралт нь болохоор юу гэхээр дахиад энэ 39 ордыг стратегийн ордод оруулж болох эсэхийг судлаад танилцуул гэдэг ийм тогтоол 2007 оны 27 дугаар тогтоол байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ 39 ордоос стратегийн орд руу орох боломжтой гэж үзэж байгаа тийм хийгдсэн судалгаа, юмнууд байна уу гэж би энэ яамныхан .../минут дуусав/

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 5 номер хариулъя.

**Г.Намчинсүрэн:** Идэрбат гишүүний асуултад хариулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн. 2007 оны Улсын Их Хурлын 27 дугаар тогтоол батлагдсанаас хойш стратегийн ач холбогдол бүхий ордод 7 ордыг хамруулахаар 2013 онд Засгийн газраас өргөн барьсан байдаг. Тухайн үеийн Их Хурал хэлэлцэж үзээд бол уг асуудлыг хэлэлцэх шаардлагагүй гээд нэг буцсан байдаг. Түүнээс хойш бол Их Хурал руу Засгийн газрын зүгээс стратегийн ач холбогдол бүхий ордод шинээр орд хамруулах асуудлыг өргөн бариагүй байгаа. Зүгээр Засгийн газрын түвшинд бол энэ стратегийн ордод ач холбогдол бүхий ордод эдгээр ордуудыг хамруулж болох юм гэдэг саналууд бол ороод явж байсан байдаг. Тухайлах юм бол хүнсний аюулгүй байдлыг хангах гэдэг хүрээндээ ч юм уу нуурын давсыг бол хамруулъя гэдгийг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас бол байнга ярьж байдаг. Мөн .../минут дуусав/

**Б.Бейсен:** Идэрбат гишүүн тодруулъя. Дараа нь гүйцээгээд хариулчих.

**Ц.Идэрбат:** Би энийг яагаад яриад байгаа юм гэхээр тэр 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлт энэ баялгийн сангийн хуулиар Монголчууд ямар ч ордоосоо ашиг хүртэх бололцоотой болчихсон байхгүй юу. Тэрийгээ ил хараад байх бололцоотой. Өнөөдөр 5 компанийн 130 мянган төгрөгийг бага гэж голж байгаа ч гэсэн энэ чинь 0 байсан байхгүй юу. Одоо энэ чинь жил болгон нэмэгдээд явна. Ирэх жил 130 биш 300 болоод ингээд явах гээд байгаа юм. Тийм учраас энэ Баялгийн сантай холбоотой, томоохон ордуудтай холбоотой асуудлуудыг энэ Хэрэг эрхлэх жоохон нээлттэй болгож өгмөөр юм биш үү гэж. Яг хэдэн орд нь стратегийн орд юм. Дахиад хэд нь орох бололцоотой юм. Тэрийг Засгийн газра, Их Хуралд оруулж ирсэн юм уу, үгүй юм уу. Их Хурал орж ирэхээр нь 2013 оны тэр 7 ордыг яагаад хассан юм. Ямар шалтгаан байсан юм. Ингэж байж нөгөө баялгийн эзэд нь баялгаа хянах, тэгээд гэрээгээ яг энэ Ораногийн гэрээ шиг их .../минут дуусав/

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 1 номер хариулъя.

**С.Наранцогт:** Идэрбат гишүүний Баялгийн сантай холбоотой хэсэг дээр нэмээд хариулъя. Тэгээд одоо нөгөө 15 орд гэдэг чинь анхны хавсралтын 16-н 1 нь нөөц нь дууссан. 15 байгаа. Үүнээс 6 нь Эрдэнэс Монголд, 9 нь хувийн хэвшил дээр байгаа. Тэгээд энэ 9 хувийн хэвшил дээр бол хэлэлцээр байгуулагдах Ерөнхий сайдын захирамж гараад, ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна.

Үндэсний баялгийн сангийн хуулийг дагалдуулаад гарсан тогтоол дотор мөн энэ өмнө гарсан 29 болоод, шинээр бас ордууд байгаа. Тэгээд үүний хил хязгаар тогтоох, шинээр стратегийн орд газар тогтоох ажлыг 2 дугаар улиралд багтааж танилцуулах үүрэг даалгаврыг уул уурхайн сайдад үүрэг болгож өгсөн байгаа. Үүнээс хойш Засгийн газрын тогтоолууд ч мөн дахиад гарсан. Тэгээд би бол уул уурхайн яам .../минут дуусав/

**Б.Бейсен:** 5 номер гүйцээж хариулъя. 1 номер хариулчихъя.

**С.Наранцогт:** Тэгээд энэ хэлэлцээр хийхтэй холбоотой бас өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар энэ хэлэлцээний явц, тэгээд үүнтэй холбоотой дахиад нөгөө уул урхайн яамны энэ стратегийн ач холбогдлын хил хязгаарыг тогтоох, шинээр таны хэлээд байгаа энэ судалгааг танилцуулах, өргөн барих асуудлыг дахиад үүрэг даалгавар өгөгдөөд, удаа дараагийн үүрэг даалгаврууд өгөгдөөд явж байгаа учраас энэ ажил удахгүй холбогдох яамнаас хийгдэж орж ирэх байх гэж ингэж бодож байгаа.

Тэгэхээр 1 дүгээрт бол одоо байгаа ордуудын бас төрийн эзэмшлийн хувь хэмжээ, өнөөдөр орж байгаа өөрчлөлтүүдээр ингээд хуримтлалын санд мөнгө нэмэгдэх тухай асуудал, мөн шинээр бас орох ийм бололцооны ордууд нэлээн байгаа гэдэг зүйл байгаа юм.

**Б.Бейсен:** 5 номер гүйцээж яриулъя.

**Г.Намчинсүрэн:** Идэрбат гишүүний асуултад нэмж хариулъя. Намчинсүрэн. Яах вэ, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж бол Ашигт малтмалын хуульд зааснаар бол үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний эсвэл жилд Монгол Улсын ДНБ-ий 5 хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой орд

гэдэг томьёололтой байдаг. Яг зүгээр ийм хэмжээний үйлдвэрлэлтэй болон ийм хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой орд гэвэл бол байхгүй. Шинээр орох. Зүгээр эсрэгээрээ үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөхүйц гэдгээрээ бид нар нэмж бол орд бас 2, 3 удаа яамны түвшин дээр бол ажлын хэсэг гаргаад ялгаж байсан тохиолдлууд байдаг. Яг одоогоор цөмийн энергийн хуульд заачихсан цацраг идэвхт ашигт малтмалын ордууд бол хуулиараа стратегийн ач холбогдол бүхий ордод хамаарч байгаа. Бусад тохиолдолд яг шууд стратегийн ач холбогдол бүхий .../минут дуусав/

**Б.Бейсен:** Наранбаатар гишүүнд асуулт асууя.

**Н.Наранбаатар:** Ер нь нөгөө асуух гэсэн асуултууд бас нэлээн давхардсан. Тэгээд орон нутагт өмнө нь ажиллаж байсан учраас бас би орон нутагтай холбоотой, хүн, малын эрүүл мэнд, байгаль орчны холбоотой л юмнуудыг би их ярьдаг юм. Орон нутгийн харилцаатай. Яагаад гэвэл бас зовлон жаргал мэднэ. Олон асуудлуудтай, олон иргэдтэй, малчидтай, сумын удирдлагуудтай уулзаж байсан. Тэгээд манай энэ том төслүүд явахгүй байгаа 1 л шалтгаан байгаа. Орон нутагтаа учраа олохгүй. Тэрийг нь олигтой гэрээ дээрээ ч зохицуулсан юм байхгүй. Энэ хуулиуд дээрээ татвар юман дээрээ ч гэсэн олигтой зохицуулсан юм байхгүй. Бүгдийг нь хурааж аваад 21 аймаг, 9 дүүрэгт нь тараачихдаг учраас л хүмүүс дургүйцээд байдаг юм л даа. Тэгээд одоо та бүхэн ингээд л харахгүй юу. Халзан бүргэдээ гээд л эсэргүүцэлтэй тулгарчихсан. Тэр орон нутагт нь ямар ч уул уурхайгаас өгөөж байхгүй. Өнөөдрийн хуулиар. Наран сэвстэй, Цагаан дэл нээгдэнэ гэхэд л наана уурхай гарах гэж байна больё гээд л.

Тэгээд одоо уурхай гарчихсан байгаа Цогтцэций, Гурвантэсрийг харахгүй юу, 2 стратегийн орд. Сумд нь хүрээд л очихгүй юу та хэд. Гамшиг. Сумын иргэдтэй уулзалт хийх юм бол зодуулна. Ийм л царайтай байгаа шүү дээ. Сургууль ч үгүй, цэцэрлэг ч үгүй, улаан тоосон дундаа тэгээд л тэр эрүүл, аюулгүй амьдрах юу ч байхгүй. Төмөр зам явлаа мал нь дайрагдаад л, тэмээ нь дайрагдана, тор татахаар ан амьтан нь үржил селекцгүй болчихно. Тэгээд л шар шороо гээд л, цөлжилт, тэмээ услах худаг ус нь байхгүй болчихсон байх жишээтэй. Гар худаг гэж ер нь байхгүй болчихлоо шүү дээ говьд. Гүний худаг 100 метр байсан 200 метрээс ч ус нь гарахаа больчихлоо. Тэгээд ийм нөхцөлд дараа дараагийн төслүүд ч явахгүй л дээ. Яг өнөөдрийн ийм бай нөхцөлөөр бол цаашаа явахгүй. Тэгэхээр энэ дээр яах вэ, бас урд төслүүдтэй харьцуулбал орон нутгийн асуудлыг гайгүй тусгаж өгсөн л байна. Гэрээ дээрээ бол тэр хугацаануудыг нь нэг хэлээдхээрэй. Тэр нөгөө бүтээн байгуулалт үе шат нь хэдэн жил юм. Уурхайн ашиглалтын үе нь хэд юм. Нөгөө сая доллар авах нь. Дараа нь тэр нөгөө дуусахаас хойш гэдэг нь бол 10 жил юм байна. Тэр хугацааг нь тодруулаадхаарай гэж асуух гэсэн юм.

Тэр АМНАТ-ыг ингээд л өсөн нэмэгдэнэ, орон нутагт нь үлддэг АМНАТ нэмэгдэнэ гээд л байдаг. Энэ чинь бас үлддэггүй юм. Одоо нөгөө Төсвийн хуулиараа АМНАТ-ыг чинь татаж аваад, тэгээд 1 томьёонд оруулаад буцаагаад тэгшитгээд хуваарилчихаар зэрэг хөөрхий тэр сумд ч олигтой юм очихгүй. Жишээ нь Өмнөговийос 1,7 их наяд төгрөг татаж аваад, буцаагаад орон нутгийн хөгжлийн санд нь хуваарилахаар 60 тэрбум. Бусад аймгууд нь 20, 30, 40 тэрбум ингээд ялгаагүй шахуу болчихдог байхгүй юу. Тэгээд ийм байхад чинь уурхайг цаашаа дэмжинэ, том төслүүд явна гэж бол байхгүй л дээ. Тэгэхээр энэ хүмүүсийн асуудал, ажлын байртай болгох асуудал орон нутгийн иргэдийг хамгийн түрүүнд. Тэр орон нутгийн иргэд, ЖДҮ эрхлэгчдийн .../минут дуусав/

**Б.Бейсен:** 5 номер микрофон хариулъя.

**Г.Намчинсүрэн:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Төслийн бүтээн байгуулалтын үе шатыг бол 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ гэж төлөвлөж байгаа. Орд бол 33 жилийн хугацаанд ашиглана. Дээрээс нь нэмэх нь 10 жилийн хугацаанд бол нөхөн сэргээлт, хаалтын мониторингоо хийгээд явна гэсэн ийм төсөөлөлтэй ТЭЗҮ дээр бол төлөвлөгдөж орж ирсэн юм.

**Б.Бейсен:** Наранбаатар гишүүн тодруулъя.

**Н.Наранбаатар:** Минутдаа багтсангүй. Тэр орон нутгийн иргэдийг ажлын байраар дэмжих дээр юу хийх юм. Тэр орон нутгийн иргэдийн тэр бараа бүтээгдэхүүн, мах, сүү худалдаж авах дээр ямар тусгайлан сургалт хөтөлбөр юу хийдэг юм. Тийм юмнууд хийх юм уу. Тэр сумыг хөгжүүлэх, тэр орон нутгийн ажилчдыг тэр сумд нь амьдруулах талаар ямар арга хэмжээ авах юм. Өмнөх гашуун туршлагауд зөндөө л манай аймагт байж байна. Одоо хүртэл ингээд л автобусаар хаа байсан Улаанбаатар энэ 2-ын хооронд яваад л, аваар осол гараад л автобус нь яагаад л ингээд л өчнөөн юмнууд байж байдаг. Энэ орон нутагтай холбоотой асуудлуудыг яаж шийдэх юм. Тэр нэмэгдсэн өртгийн албан татварыг 0 хувь гэсэн байна лээ. Тэгээд экспортод гарч баяжмал гэж үзэх юм уу, эцсийн бүтээгдэхүүн гэж үзэх юм уу. Яагаад 0 хувиар байгаа юм гэх мэтчилэн ийм бүх асуултуудад хариулт авъя.

**Б.Бейсен:** 1 номер хариулъя.

**С.Наранцогт:** Наранбаатар гишүүний асуултад тодруулж хариулъя. Таны хэлдэг бас үнэн. Гэрээ дээр ингээд бүхэл бүтэн орон нутгийн хөгжил гэсэн бүлэг орсон. Тэгээд энийг ингээд бүгдийг нь уншихаар их цаг орно. Энэ дээр бол яг таны ярьж байгаа асуудлууд бол бүгд туссан байгаа. Ялангуяа орон нутагт шилжин ажиллах, тэр үед орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх, ингээд нөхцөлийг жишээлбэл ажилчдын гэр бүлийн хамтаар Дорноговь аймгийн Улаанбадрах сумд шилжин суурьших нөхцөлийг бүрдүүлж дэмжлэг үзүүлнэ гээд. Ажиллагсдын бүрэлдэхүүний хувьд бол яах вэ бүтээн байгуулалтын хувьд бол 40, яг үйлдвэрлэл явуулаад ирэхээр 90 хувь нь Монгол ажилчид. Тэр дотроо ингээд орон нутгийн ажилчдын хувь хэмжээг ингээд заагаад өгчихсөн ийм байдлаар ер нь бол энэ ингээд энэ бүхэл бүтэн бүлэг орсон.

Яагаад гэвэл энэ дээр орон нутгийн төлөөлөл, иргэний нийгмийн төлөөлөл яг энэ хэсгийн бас ажлын дэд .../минут дуусав/

**Б.Бейсен:** 1 номер гүйцээж хариулъя.

**С.Наранцогт:** Орж ажилласан учраас эд нар бас нэлээн сайн заалтуудыг ингээд оруулж чадсан юм. НӨАТ-ын хувьд бол манай Монгол улс дээр эцсийн бүтээгдэхүүн гэдэг ийм аж үйлдвэрийн бүтээгдэхүүний жагсаалтыг батлаад явдаг. Энэ жагсаалтад энэ шар нунтаг 2015 онд оруулсан юм байна лээ. Тэгээд ийм байгаа учраас яг одоогийн байгаа хууль, эрх зүйгээр бол яалт ч үгүй тэр 0 хувьд орохоос өөр аргагүй байгаа. Тэгээд бид нар энийг зүгээр бас оруулахгүй байх гэж нэлээн яасан. Тэгээд нөхдүүд бол хууль, эрх зүйн хүрээнд бусад уул уурхайн компаниудын хүрээнд бид нар адилхан үзэгдэх ёстой гээд. Тэгээд яг тэр заалтаар нь оруулсан юм. Өөрөөр хэлбэл бид нар хууль, эрх зүйгээ өөрсдөө өөрчлөөд энэ

адилхан уул уурхайн компаниуд, адилхан ялгаварлан гадуурхахгүйгээр ингээд хийх юм бол энийгээ дагахаар тэрнээс бишээр ... /минут дуусав/

**Б.Бейсен:** Энхтуяа гишүүн байхгүй байна. Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэбат:** Ажлын хэсгийн гишүүний хувьд бас энэ гэрээ дээр өмнөх өмнөх гэрээнүүдээс бас энэ хүний эрхтэй холбоотой нэлээн олон бас шинэ заалтууд орсон. Цаашдаа гэрээнд бол жишиг болохоор. Оюутолгойг ч гэсэн анх ийм саналууд өгч байхад уг нь олон улсын компани шууд болон дам нөлөөллийн үр ашиг гэдэг өөрөө их чухал. Ялангуяа энэ төслийн үед туслан гүйцэтгэгч компаниуд бараа бүтээгдэхүүн нийлүүлдэг, үйлчилгээ нийлүүлдэг энэ компаниуд нь үндсэн гэрээн дээр байж байгаа шаардлагуудыг давхар шаардах энэ зүйлийг гэрээ дээр тавьж өгвөл. Тухайлбал Оюутолгой компанид хоол нийлүүлдэг, бүтээгдэхүүн нийлүүлдэг нэг Support Mongol Servis гээд компани байсан. Францын бас хөрөнгө оруулалттай. Гэтэл тэнд ажиллаж байгаа үйлчилгээний ажилчид нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин авдаг. Яагаад гэхээр үндсэн төслийн гэрээний ажилтан биш эд нар гэдэг байдлаар ингээд нугалаа гаргаад яваад байдаг учраас би энэ гэрээний юун дээр бас тиймэрхүү зүйлүүдийг үндсэн энэ гэрээ дээр байгаа зүйлүүдийг бараа бүтээгдэхүүн нийлүүлдэг, туслан гүйцэтгэгч үйлчилгээ нийлүүлдэг энэ юунуудаа бас үндсэн нэгэн адил тавигдах шаардлага дээрээ тавьж явахгүй бол бас болдоггүй ийм асуудлууд байдаг. Петро Чайна дээр бас тийм байсан. Ажилтан нийлүүлэх гэрээгээр 1 мянга гаруй ажилтан авдаг байсан. Үндсэндээ бараг хөдөлмөр хөлсний доод хэмжээгээр. Дундаас нь хэдэн хүмүүс ашиг олоод, тэнд бол хүний эрх гэрээ дээр байсан гоё гоё ийм заалтууд байхгүй болчихдог. Тийм учраас энэ дээрээ бас анхаараарай гэдгийг бас би хэлмээр байна.

Яагаад гэхээр ажлын хэсгийн гишүүний хувьд бас яг энэ гэрээг нэг бүрчлэн бол Их Хурал дээрээ ярихгүй гэдэг үүднээс би энэ асуудлуудыг бол яасан. Бичгээр бол яах вэ ерөнхийдөө саналаа өгсөн. Тийм учраас түрүүн Учрал сайд бас хэллээ. Хэдийгээр гэрээ дээр маш чухал заалтууд орж ирсэн, бас нэлээн жишиг болохуйц цааш цаашдын төслийн юунд байгаа боловч хэрэгжүүлнэ гэдэг асуудал бас байдаг. Тэгэхээр энэ гэрээ дээр байж байгаа урьдчилсан үнэлгээний тайлангууд гээд гаргана гэсэн байна лээ. Явцын тайлангуудыг бас авч үздэг байх хэрэгтэй. Олон улсын тэр гэрээнүүд дээр үндсэн дамнасан корпорацуудын хийдэг гэрээнүүд дээр юу вэ гэхээр явцын болон нийгмийн үнэлгээний гэрээнүүд гэдэг зүйлийг бол авч үзэж байх зайлшгүй шаардлагатай байдаг юм. Энэ дотроо харин тэр байгаль орчин, хүн, эрүүл мэнд өөрөө бусад дан болон шууд нэлээн олон улсын хөдөлмөрийн стандартын хэрэгжилт гэх мэтчилэн ийм зүйлүүдээ аваад явах нь зүйтэй гэж бол харж байгаа. Энэ дотор бол байна лээ.

Гэхдээ явцын болон хаалтын үнэлгээ, хаалтын юун дотор энд 1600 орчим, 800 орчим ажилтан ажиллана. Тэр хүмүүс маань ирээдүйд хаана ажиллах вэ. Хааш нь шилжүүлж тавих вэ гэдэг энэ бүгдийг бас тавьж өгөөрэй гэдгийг бол хэлмээр байна. Цалин хөлсний хувьд тодорхой ижил хөдөлмөрт юу гээд байж байгаа. Орон сууцын асуудал гээд байж байгаа. Одоо ер нь манай энэ уул уурхайн төслүүд дээр ерөнхийдөө 1 контейнерт амьдруулдаг, гэрт амьдруулдаг. 10, 20 жил болсон. Оюутолгой бол одоогоос авхуулаад орон сууц барина гэсэн л нэг юм тавьж байна лээ. 50 сая доллар тавьсан гээд. Петра Чайна бол яг хэвээрээ. Миний үед 10 гаруй жилийн өмнө байж байсан. Орон сууц барина л гэж байсан. Байхгүй. .../минут дуусав/



**Б.Бейсен:** 1 минут сунгая.

**С.Эрдэнэбат:** Тэгэхээр энэ гэрээ дээр ажилчдын тэр орон сууцын асуудал гэдэг дээрээ бас анхнаас нь юу тавьж байхгүй бол ерөнхийдөө тэр Катко дээр ч гэсэн очиход ерөнхийдөө яах вэ энэ кампын байдалтай л байгаад байгаа. Тэгэхээр хамгийн ойрхон 20, 30 жилийн дараа тэнд суурин үүснэ. Энэ төслийг хэрэгжүүлснээрээ тэнд бас нэг жижигхэн сум нь өөрөө Хот шиг энэ тэр болох ийм зүйлийг нь анхаарч үзэх шаардлагатай шүү гэдгийг бас би хэлмээр байна.

Тэгээд энд нэг зүйлийг тодруулж ярихад эрүүл мэндийн зарим мэдээллүүд нь нууц энэ тэр гээд тавьчихсан байна лээ. Би яах вэ энэ дээр хэлэхэд Оюутолгой дээр бас анх тэгж ярьж байсан юм. Сүүлдээ бараг манай Хөдөлмөрийн сайд нар хүртэл үнэлгээ, хяналт хийх гээд очиход оруулахгүй. Ажилтнуудын мэдээлэл нууц гээд тавьчихдаг. Гэтэл ажилтнууд нь асуудал тавиад байдаг. Тэр мэдээлэлтэй нь танилцах эрхгүй байгаад байна. Нөгөө хянах үнэлэх ийм албан тушаалтнууд нь гэх мэтчилэн ийм юмнууд явцын дундаас маргаан гарахгүй үүднээс анхнаас нь гэрээ дээрээ та бүгд маань бас нэлээн анхаараарай гэдэг зүйлийг бол хэлмээр байна. Баярлалаа.

**Б.Бейсен:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Замира гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүн.

**Б.Бат-Эрдэнэ:** Би маш хурдан хэлчихье. Энэ нөгөө олон нийтийн анхаарлын төвд байгаа ийм гэрээ, хэлэлцээр олон улсын түвшинд явж байгаа, гадаад хөрөнгө оруулалттай холбоотой юман дээр манай энэ мэргэжлийн хариулж байгаа хүмүүс өөрсдөө их анхааралтай хариулт өгөхгүй бол түрүүн тэр 4 номер дээр 179км гээд хэлчихсэн. 179км одоохондоо дэлхийн гүн лүү өрөмдөөгүй байгаа шүү дээ. 12,3км л хамгийн дээд түвшинд супер гүн өрөмдлөг хийчихсэн явж байгаа. Техник технологийн дэвшил ч тэр түвшинд очоогүй. Таныг өөрийн чинь хэлээд байна. Таны өөрийн чинь хэлсэн дээр л хэлчихье. Тэгэхээр энэ 179км гээд өөрсдөө энэ алдаатай юмнуудаа их сайн зөв хэлж байхгүй бол энэ чинь өөрөө эргээд нийгэмд бас юу билээ гэдэг. Тэгээд яах вэ, Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсан. Иргэд өөрсдөө стратегийн ордын 34 хувийг эзэмших ийм нөхцөл бүрдсэн. Ингээд ялангуяа мэргэжилтнүүдээс бүрдсэн ийм чадварлаг баг ажиллаад явж байгаа нь өөрөө эргээд гэрээ нэлээн ахицтай, урагштай явах боломж бүрдсэн.

Хамгийн гол нь бол нээлттэй, ил тод явагдаж байгаа гэдэг нь, тэгээд түрүүн бас манай Наранбаатар гишүүн хэлсэн. Идэрбат гишүүн ч бас хэлж байна. Энэ орон нутагт орон нутгийг хөгжүүлэх орон нутгийн санд эргээд орон нутгийн иргэдэд дэмжлэг болохоор ийм бүтэн заалт орж өгч байгаа нь бол энэ гэрээ бас цаашдаа бол ахицтай нэлээн сайн явах боломж бүрдэж байгаа болов уу гэж харж байгаа. Тэгээд та хэд маань дараа дараагийн түвшинд хэлэх үгээ бас сайн бодож хэлээрэй гэдгийг сануулах гэсэн юм. Баярлалаа.

**Б.Бейсен:** Замира гишүүн үг хэлье.

**С.Замира:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ төсөл нэлээд удаан хугацаагаар судлагдаад Монгол Улсын Ерөнхийлөгч хүртэл энд оролцоод, одоо Их Хурлын гишүүд тэр газарт нь очоод бүгдийг нь үзээд анхаарлын төвд байгаа гэрээ. Тийм учраас энд та бүхэн нэлээд нямбай сайн ажиллах байх гээд бодож байна.

Тэр Казакстанд байгаа үйлдвэр нь их сайхан, дэг журамтай, хууль дүрэмтэй бас маш хатуу хяналт дор явдаг юм байна. Манай үйлдвэрүүд бас тэгж явах байх гээд найдаж байна. Тэгээд сая гишүүдийн хэлж байгаа орон нутгийг хөгжүүлэх тал дээр орон сууц ард түмэнд барьж өгөх, ЖДҮ-ээ хөгжүүлж өгөх тал дээр бас анхаарал хандуулна гэж найдаж байна. Бас тэгээд сая сонсож байхад хүхрийн хүчил зөвхөн энэ үйлдвэр бол 208 мянган тонн жилдээ хэрэглэнэ гээд сонслоо. Мөн үү. Тэгэхээр энийг бол өөрсдөө үйлдвэрлэх тал дээр бас анхаарлаа хандуулна уу гэж та бүхнээс хүсэх байна. Амжилт хүсье. Баярлалаа.

**Б.Бейсен:** Гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт явуулахаас өмнө нэг юу танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Батчимэг гишүүнээс санал ирүүлсэн байгаа. Энийг протоколд тэмдэглүүлээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлье. Цаашид энэ гэрээг үзэглэхэд бас гишүүний саналыг анхаарахыг хүсье. Манай Байнгын хороогоор зөвшилцөх асуудлыг хэлэлцэж байгаа учраас энийг хэлэлцэх боломжгүй гэдгийг хэлье. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 86,7 хувьтай дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газар болон Монгол Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компанийн хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг зөвшилцөх асуудлыг хэлсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

16.23 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*